



2019 оны 10 дугаар сарын 14
№39/1092/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Санхүүжилтийн ерөнхий
хөтөлбөр соёрхон батлах
тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Монгол Улсын 2018 оны
төсвийн гүйцэтгэл батлах
тухай**

**Монгол Улсын
олон улсын
гэрээ**

**Монгол Улсын Засгийн газар,
Азийн хөгжлийн банк хооронд
байгуулсан Санхүүжилтийн
ерөнхий хөтөлбөр**

**ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

319. Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр
соёрхон батлах тухай 1437

320. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай 1438

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

321. Монгол Улсын 2018 оны төсвийн
гүйцэтгэл батлах тухай Дугаар 76 1438

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

322. Засгийн газарт чиглэл өгөх тухай Дугаар 153 1439

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

323. Журам батлах тухай Дугаар 204 1441

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

324. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн
банк хооронд байгуулсан Санхүүжилтийн
ерөнхий хөтөлбөр 1449

325. Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын
Зээлийн хэлэлцээр
(АХБ-ны Уур амьсгалын ногоон сан)
(Улаанбаатар хотын төлбөрийн
чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан
зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл) 1451

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 09 дүгээр
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 09 дүгээр
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Уур амьсгалын ногоон сангийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 6,828,374.0 сая /зургаан их наяд найман зуун хорин найман тэрбум гурван зуун далан дөрвөн сая/ төгрөгөөр баталсугай.

2. Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 7,181,902.8 сая /долоон их наяд нэг зуун наян нэгэн тэрбум есөн зуун хоёр сая найман зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 09 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Гал түймэр, гамшгийн аюултай тэмцэх чадавхыг сайжруулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ерөнхий сайд У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай:

1.1. Гал түймэр, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдлийг бууруулах болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэх, зарцуулах болон тусгай зориулалтын автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авах, татвараас чөлөөлөхтэй холбоотой хууль тогтоомжийн зохицуулалтыг судалж, боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

1.2. Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, сэргээн босгох үйл ажиллагаанд хэрэглэж байгаа техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг стандартын шаардлагад нийцүүлэх, онцгой байдлын байгууллагыг туулах чадвар сайтай машин, холбооны хэрэгслээр хангах болон лабораторийн шинжилгээний багаж, шаардлагатай бусад тоног төхөөрөмж, тусгай хэрэгцээт материалын хангамжийг сайжруулах арга хэмжээ авах;

1.3. Гал түймэртэй тэмцэх, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх зорилгоор гал унтраах, аврах анги, шуурхай бүлгийн бие бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх, эрсдэл нөхцөл байдлыг эрт илрүүлэх, эрэн хайх, аврах, яаралтай тусламж үзүүлэх нисэхийн нэгж байгуулах, ой, хээрийн түймрийн эрсдэл бүхий сумдад гамшгаас хамгаалах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий албан хаагчийн орон тоог бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх;



1.4. Гал түймэртэй тэмцэх, гамшгаас хамгаалах талаарх олон нийтийн санаачилгыг дэмжих зорилгоор орон нутаг дахь ойн анги, нөхөрлөл, сайн дурын бүлгийг сурган дадлагажуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, гал түймэр, гамшиг, ослын голомтод ажилласан тохиолдолд урамшуулал олгох асуудлыг судлан, холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

1.5. Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, аюул тулгарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зохион байгуулалтын талаар олон нийтийг мэдээлэл, заавар, зөвлөмжөөр хангах, хүүхэд залуучуудад эх оронч, байгаль орчноо хайрлан хамгаалах зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэвлэл, мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх;

1.6. Гал түймэр, гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх чиглэлээр жил бүр хөрөнгө төлөвлөж, болзошгүй эрсдэлийг бууруулах, салбар хоорондын мэдээлэл харилцан солилцох, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шуурхай удирдлагын төвийн чадавхыг сайжруулах;

1.7. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд тооцох хариуцлагыг чангатгах;

Хоёр. Гамшиг осолгүй, аюулгүй Монгол Улсын төлөө бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх агуулга бүхий мэдээлэл түгээх, бүтээл, нэвтрүүлэг хийх үйлсэд иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг идэвхийлэн оролцохыг уриалсугай.

Гурав. Энэхүү зарлигийн хэрэгжилтийн явцыг Монгол Улсын Ерөнхийлөгчид жил бүр мэдээлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ерөнхий сайд У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 5 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 204

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2, 7.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Түүхэн үйл явдал, тэмдэглэлт өдөр”-ийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт, “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ё.БААТАРБИЛЭГ

Засгийн газрын 2019 оны 204 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛЫН ОЙ, ТЭМДЭГЛЭЛТ ӨДРИЙН ЖАГСААЛТ

1. Түүхэн үйл явдлын ой:

1.1. Хүннү гүрэн байгуулагдсаны ой-жил бүрийн Цагаан сар-билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдөр;

1.2. Халх голын байлдааны ялалтын ой-жил бүрийн 8 дугаар сард;

1.3. Дэлхийн II дайн дууссаны болон 1945 оны чөлөөлөх дайны ялалтын ой-жил бүрийн 8 дугаар сард;



1.4. Монгол Улсын баруун хил дээр 1948 онд болсон зэвсэгт тулгаралт дууссаны ой-жил бүрийн 6 дугаар сард;

1.5. 1990 оны Ардчилсан хувьсгалын ой-жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдөр;

1.6. Ардчилсан сонгуулийн ой “Бүрэн эрх, ардчилсан сонгуулийн өдөр”-жил бүрийн 7 дугаар сарын 29-ний өдөр;

1.7. Монгол хүн сансарт ниссэний болон сансрын хамтарсан нислэгийн ой-жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдөр.

2. Салбарын, зарим ажил, мэргэжлийн ажилтны тэмдэглэлт өдөр:

2.1. Хэвлэл, мэдээллийн ажилтны өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 6-ны өдөр;

2.2. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдөр;

2.3. Усны болон цаг уурын өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 23-ны өдөр;

2.4. Хөнгөн, хүнсний аж үйлдвэрийн ажилтан, ажилчдын өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 26-ны өдөр;

2.5. Дэлхийн театрын өдөр-жил бүрийн 3 дугаар сарын 27-ны өдөр;

2.6. Дэлхийн ном, зохиогчийн эрхийг хамгаалах өдөр-жил бүрийн 4 дүгээр сарын 23-ны өдөр;

2.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр-жил бүрийн 4 дүгээр сарын 28-ны өдөр;

2.8. Газрын харилцааны ажилтны өдөр-жил бүрийн 5 дугаар сарын эхний Ням гараг;

2.9. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 3 дахь Бямба гараг;

2.10. Газрын тосны салбарын ажилтны өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 4 дэх Ням гараг;

2.11. Иргэний агаарын тээвэрчдийн өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 4 дэх Ням гараг;

2.12. Олон улсын музейн өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 18-ны өдөр;

2.13. Энхийг сахиулагчдын өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 29-ний өдөр;

2.14. Банкны салбарын ажилтны өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 2-ны өдөр;

2.15. Мал эмнэлгийн салбарын ажилтны өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 2 дахь Бямба гараг;

2.16. Мэргэжлийн хяналтын ажилтны өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 2 дахь Ням гараг;

2.17. Онцгой байдлын албаны өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 20-ны өдөр;

2.18. Хуульчдын өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 4 дэх Ням гараг;

2.19. Тамирчдын өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 4 дэх Ням гараг;

2.20. Тагнуулын байгууллагын ажилтны өдөр-жил бүрийн 7 дугаар сарын 3-ны өдөр;

2.21. Хоршоологчдын өдөр-жил бүрийн 7 дугаар сарын эхний Ням гараг;

2.22. Цагдаагийн болон дотоодын цэргийн алба хаагчдын өдөр-жил бүрийн 7 дугаар сарын 19-ний өдөр;

2.23. Авто тээвэрчдийн өдөр-жил бүрийн 7 дугаар сарын 3 дахь Ням гараг;

2.24. Мэдээллийн технологи, харилцаа холбооны ажилтны өдөр-жил бүрийн 7 дугаар сарын сүүлийн Ням гараг;

2.25. Төмөр замчдын өдөр-жил бүрийн 8 дугаар сарын эхний Ням гараг;



2.26. Эрүүл мэндийн салбарын ажилтны өдөр-жил бүрийн 8 дугаар сарын хоёр дахь Ням гараг;

2.27. Прокурорын албаны өдөр-жил бүрийн 8 дугаар сарын 14-ний өдөр;

2.28. Эрчим хүчний ажилтны өдөр-жил бүрийн 8 дугаар сарын 3 дахь Ням гараг;

2.29. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны өдөр-жил бүрийн 8 дугаар сарын 4 дэх Ням гараг;

2.30. Барилгачдын өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын эхний Ням гараг;

2.31. Соёл, урлагийн ажилтны өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын 2 дахь Ням гараг;

2.32. Үндэсний татварын ажилтны өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын 2 дахь Ням гараг;

2.33. Хилчдийн өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын 17-ны өдөр;

2.34. Ой модны салбарын ажилчдын өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын гурав дахь Ням гараг;

2.35. Дэлхийн энх тайвны өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын 21-ний өдөр;

2.36. Аялал, жуулчлалын өдөр-жил бүрийн 9 дүгээр сарын 27-ны өдөр;

2.37. Багш нарын өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 5-ны өдөр;

2.38. Оюутны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 5-ны өдөр;

2.39. Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний ажилтны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 2 дахь Ням гараг;

2.40. Стандарт, хэмжил зүйн ажилтны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 14-ний өдөр;

2.41. Хүний нөөцийн ажилтны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдөр;

20-ны өдөр; 2.42. Гаалийн ажилтны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын

20-ны өдөр; 2.43. Маркетеруудын өдөр-жил бүрийн 10 дугаар сарын

дахь Ням гараг; 2.44. Геологичдын өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 3

дэх Ням гараг; 2.45. Авто замчдын өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 4

сарын 2 дахь Ням гараг; 2.46. Хөдөө аж ахуйн ажилтны өдөр-жил бүрийн 11 дүгээр

дүгээр сарын 23-ны өдөр; 2.47. Улсын бүртгэлийн ажилтны өдөр-жил бүрийн 11

ний өдөр; 2.48. Даатгалын өдөр-жил бүрийн 11 дүгээр сарын 24-

дүгээр сарын 4 дэх Ням гараг; 2.49. Шинжлэх ухааны ажилтны өдөр-жил бүрийн 11

өдөр; 2.50. Архивчдын өдөр-жил бүрийн 12 дугаар сарын 5-ны

дугаар сарын 2 дахь Ням гараг; 2.51. Санхүү, эдийн засагчдын өдөр-жил бүрийн 12

сарын 3 дахь Ням гараг; 2.52. Худалдааны ажилчдын өдөр-жил бүрийн 12 дугаар

ны өдөр; 2.53. Уурхайчдын өдөр-жил бүрийн 12 дугаар сарын 25-

29-ний өдөр. 2.54. Дипломат албаны өдөр-жил бүрийн 12 дугаар сарын

3. Бусад тэмдэглэлт өдөр:

31-ний өдөр; 3.1. Иргэний нийгмийн өдөр-жил бүрийн 1 дүгээр сарын

өдөр; 3.2. Наурызын баяр-жил бүрийн 3 дугаар сарын 22-ны



3.3. Хөрс хамгаалах үндэсний өдөр-жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоногийн Бямба гараг;

3.4. Үндэсний бичиг үсгийн баяр-жил бүрийн 5 дугаар сарын эхний Ням гараг;

3.5. Хүмүүнлэгийн өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 8-ны өдөр;

3.6. Байгаль хамгаалах өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 2 дахь Ням гараг;

3.7. Мод тарих өдөр-жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь Бямба гараг;

3.8. Бурхан багшийн их дүйцсэн өдөр-билгийн тооллын зуны эхэн сарын арван тавны өдөр.

Засгийн газрын 2019 оны 204 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛЫН ОЙ, ТЭМДЭГЛЭЛТ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд зааснаас бусад түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулахад энэ журмыг мөрдөнө.

1.2. Монголын болон дэлхийн түүхэнд онцгой гавьяа байгуулсныг тодорхойлох шинжлэх ухааны байгууллагын бодит баримт бүхий дүгнэлтээр нотлогдсон түүхэн хүн, Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатрын мэндэлсэн болон тухайн салбар байгуулагдсан өдрөөс 100 болон түүнээс дээш 50 жилийн давтамжтай тэгш ойг тэмдэглэнэ.

1.3. Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалтын 1.2-1.4-д заасан түүхэн үйл явдлын ойг тухайн үйл явдал болсон өдрөөс хойш 10 жилийн давтамжтай тэмдэглэнэ.

1.4. Байгууллагын тэгш ойг байгуулагдсан өдрөөс хойш 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн тухайн байгууллагын удирдлага холбогдох шийдвэр гаргаж тэмдэглэнэ.



1.5. Дараахь тохиолдолд түүхэн үйл явдал, тэмдэглэлт ойг тэмдэглэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ:

1.5.1. Шинжлэх ухааны академийн дүгнэлт, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн, Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалтад ороогүй түүхэн үйл явдал, түүхэн хүний тэгш ойг;

1.5.2. батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалтын 1.2-1.4-д заасан түүхэн үйл явдлын ойг;

1.5.3. гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн олон улсын хэмжээний түүхэн үйл явдлын тэгш ойг.

1.6. Салбарын тэгш ойг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон нутгийн байгууллагын тэгш ойг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тэмдэглэнэ.

1.7. Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатрыг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх зорилгоор түүний тэгш ойг тэмдэглэх асуудлыг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

1.8. Нэгдсэн Үндэстний байгууллага, түүний төрөлжсөн болон олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр шийдвэрлэсэн, зөвлөмж болгосон тэмдэглэлт өдрийг тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

Хоёр. Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх

2.1. Түүхэн үйл явдал, түүхэн хүн, энэ журмын 1.7-д заасан ойг тэмдэглэх ажлын хүрээнд дараахь арга хэмжээг зохион байгуулж болно:

2.1.1. түүхэн үйл явдлын болон түүхэн хүний гавьяа, гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдол, сургамжийг хүүхэд, залууст танин мэдүүлж, сурталчлах;



2.1.2. шинжлэх ухааны тодорхой салбар, чиглэлээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;

2.1.3 урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах;

2.1.4. ном, кино бүтээх;

2.1.5. хөшөө, дурсгалын самбар, багана босгох;

2.1.6. бусад.

2.2. Салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тэмдэглэх өдрийн хүрээнд тухайн жилд тодорхой сэдэв, уриан дор дараахь арга хэмжээг зохион байгуулж болно:

2.2.1. тухайн салбарын ололт амжилтыг олон нийтэд мэдээлж сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох;

2.2.2. иргэдэд үйлчилгээ үзүүлэх, тэдний санал, хүсэлтийг сонсох, бүтээлч ажил, үйл ажиллагаанд оролцуулах;

2.2.3. ажилтан ажилчдын хөдөлмөр, бүтээлийг тодруулан алдаршуулах, хөдөлмөрийн алдар тэмдэглэх, шагнаж урамшуулах;

2.2.4. үдэшлэг, өдөрлөг, оюун ухаан сорих болон биеийн тамирын тэмцээн, ажил, мэргэжлийн уралдаан зохиох.

2.3. Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх асуудлыг тухайн байгууллага үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвтөө тусган батлуулж, зардлын гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана.

2.4. Аймаг, нийслэлд хөшөө, дурсгалын самбар, багана босгох тохиолдолд түүний загвар, тодорхойлолтыг орчны архитектур төлөвлөлттэй уялдуулан аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллагын гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар батална.

2.5. Түүхэн үйл явдал, ойг тэмдэглэхэд шаардагдах зардлыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, төрийн бус байгууллагын хандив, ивээн тэтгэгчдийн хөрөнгөөр санхүүжүүлж болно.



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛС БОЛОН АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ) ХООРОНД БАЙГУУЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР 2019-2020 ОНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮҮНЭЭС

(А) Монгол Улс “Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратеги” (2017-2020), “Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө” (2019-2021)-ний дагуу 2019-2020 онд хөгжлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор АХБ-аас зээлийн санхүүжилт хүсч болно.

(Б) Монгол Улс, АХБ ерөнхий хөтөлбөр байгуулах хүсэлтэй байгаа ба энэ хүрээнд Монгол Улс АХБ-ны зээлийн нөхцөлийн дагуу АХБ-аас зээлийн санхүүжилт хүсч болно.

ИЙМЭЭС талууд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 1.01. Дор дурдсан Хэсэг 1.02 болон 1.03-т заасны дагуу Монгол Улсын хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор АХБ 2019-2020 онд зээлийн санхүүжилт олгож болно. Зээлийн санхүүжилтийн хэмжээ¹ нь дор дурдсан хэмжээнээс хэтрэхгүй байна:

- (а) 2019 онд хоёр зуун жаран дөрвөн сая ам.доллар (264,000,000 ам.доллар)-ыг АХБ-ны энгийн эх үүсвэрийн сангийн энгийн болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно;
- (б) 2020 онд далан сая ам.доллар (70,000,000 ам.доллар)-ыг АХБ-ны энгийн эх үүсвэрийн сангийн энгийн болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно;

Хэсэг 1.02. Хөгжлийн төсөл эсхүл хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн хэмжээг Монгол Улс, АХБ-тай байгуулах зээлийн хэлэлцээрийн хүрээнд тохирно. Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн ерөнхий мэдээлэл Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2019-2021)-нд туссан болно.

¹Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хэсэг 1.01-г заасан нийт зээлийн хэмжээ/хязгаарт олон үе шаттай санхүүжилтийн хөтөлбөрүүдийн эх үүсвэр ороогүй ба олон үе шаттай хөтөлбөрийн үе шат тус бүр Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2019-2021)-нд туссан болно.



Хэсэг 1.03 АХБ хөгжлийн төсөл, хөтөлбөр тус бүрийн зээлийн санхүүжилтийг Монгол Улсын хүсэлтийн дагуу болон АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр батлагдсаны үндсэн дээр олгоно. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс нь заавал зээл хүсэх, эсхүл АХБ нь заавал зээл олгох үүрэг хүлээхгүй болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 2.01. АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгох энгийн зээлийн нөхцөл нь (а) 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн үйл ажиллагааны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.02. АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөл нь (а) 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн үйл ажиллагаа (хөнгөлөлттэй)-ны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.03. Монгол Улс нь АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөгжлийн төсөл эсхүл хөтөлбөрийг АХБ-ны авилгын эсрэг арга хэмжээ, хамгаалал, жендер, худалдан авалт, зөвлөх үйлчилгээ болон зээлийн ашиглалтын бодлогууд мөн холбогдох зээлийн хэлэлцээр болон төслийн баримт бичигт заасны дагуу хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 3.01. Энэхүү хөтөлбөрийг талуудын ил тод байдлын болон/ эсхүл мэдээлэл хүргэх тухай бодлогын дагуу нийтэд ил тод болгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 4.01. Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар хүчин төгөлдөр болох ба 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр байна. Энэхүү хөтөлбөрийг талууд бичгээр тохиролцсоны дагуу сунгаж болно. Талуудын аль нэг Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг нөгөө талтайгаа зөвшилцсөний үндсэн дээр хүчингүй болгоно.

--Заалтуудын төгсгөл--

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд тохиролцсон дээрх заалтуудыг энд хөрвүүлсэн болно.



Хөтөлбөрийг 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр Англи хэл дээр 2 хувь байгуулсан ба эх бичвэр бүр ижил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ төлөөлж АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ төлөөлж

Ч.ХҮРЭЛБААТАР

Сайд
Сангийн яам

ЁЛАНДА ФЕРНАНДЕЗ ЛОММЕН

Монгол Улсыг хариуцсан захирал
Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛС

БОЛОН

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

ХООРОНДЫН

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(АХБ-ны Уур амьсгалын ногоон сан)

(Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл)

2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр

МОНГОЛ УЛС (“Зээлдэгч” гэх) болон АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (“АХБ” гэх) тус банкны бие даасан бүрэн эрхийн хүрээнд бус Уур амьсгалын ногоон сан (“УАНС”)–гийн магадлан итгэмжлэгдсэн хэрэгжүүлэгч байгууллагын хүрээнд 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР.

ҮҮНД:

(А) Зээлдэгч нь Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээр (ийнхүү тухайн гэрээнд тодорхойлсон)-ийн Хуваарь 1-т тодорхойлсон төслийг хэрэгжүүлэх зорилгоор АХБ-нд зээл авах хүсэлт гаргасан;



(B) АХБ нь УАНС-гийн мөнгөн хөрөнгийг итгэмжлэн хүлээн авч, удирдан зарцуулахаар АХБ-ны Уур амьсгалын ногоон санг байгуулсан;

(C) Зээлдэгч болон АХБ-ны хооронд 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зэрэг байгуулсан зээлийн хэлэлцээр (“Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээр”)-ээр АХБ нь уг Төслийн зорилгоор Зээлдэгчид тус банкны энгийн хөрөнгийн нөөцөөс хорин сая доллар (\$20,000,000)-ын зээл (“Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээл”)-ийг олгохоор шийдвэрлэсэн;

(D) Зээлдэгч болон АХБ-ны хооронд 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зэрэг байгуулсан зээлийн хэлэлцээр (“Энгийн үйл ажиллагааны зээлийн хэлэлцээр”)-ээр АХБ нь Зээлдэгчид Төслийн зорилгоор тус банкны энгийн хөрөнгийн нөөцөөс жаран сая доллар (\$60,000,000)-ын зээл (“Энгийн үйл ажиллагааны зээл”) олгохоор шийдвэрлэсэн;

(E) Зээлдэгч болон АХБ-ны хооронд 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрээр АХБ нь Уур амьсгалын ногоон сан (“УАНС” гэх) болон АХБ-ны хооронд 2017 оны 8-р сарын 17-нд байгуулсан “Магадлал итгэмжлэлийн ерөнхий гэрээ” (МИЕГ), 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан “Сангийн үйл ажиллагааны гэрээ” (СҮАГ)-нд заасан УАНС-гийн магадлан итгэмжлэгдсэн хэрэгжүүлэгч байгууллагын эрх, мэдлийн хүрээнд АХБ-ны Уур амьсгалын ногоон сангаас тавин сая доллар (\$50,000,000)-ын буцалтгүй тусламж (“УАНС-гийн буцалтгүй тусламж” гэх)-ийг уг Төслийг хэсэгчлэн санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс олгохоор шийдвэрлэсэн;

(F) Зээлдэгч болон АХБ-ны хооронд 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр (“ӨТС-ийн буцалтгүй тусламжийн хэлэлцээр” гэх)-ээр АХБ нь Өндөр технологийн сан (“ӨТС” гэх)-гаас гурван сая доллар (\$3,000,000)-ын буцалтгүй тусламж (“ӨТС-гийн буцалтгүй тусламж” гэх)-ийг уг Төслийн тодорхой үйл ажиллагааг хамтран санхүүжүүлэх зорилгоор олгохоор шийдвэрлэсэн;

(G) Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (“НЗДТГ” гэх) нь АХБ болон НЗДТГ-ын хооронд 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Төслийн гэрээ (“НЗДТГ-ын төслийн гэрээ”-гэх)-ний дагуу, Монгол Улсын Хөгжлийн Банк (“МУХБ” гэх) нь АХБ болон МУХБ, ХУК-нийн хооронд 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан Төслийн гэрээ (“МУХБ-ны төслийн гэрээ” гэх)-ний дагуу тус тус уг Төслийг хэрэгжүүлнэ; мөн

(H) АХБ нь Уур амьсгалын ногоон сан (“УАНС” гэх) болон АХБ-ны хооронд байгуулсан МИЕГ болон СҮАГ-нд заасан УАНС-гийн магадлан итгэмжлэгдсэн хэрэгжүүлэгч байгууллагын эрх, мэдлийн хүрээнд энэхүү



хэлэлцээр, Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээр, Энгийн үйл ажиллагааны зээлийн хэлэлцээр, УАНС-гийн буцалтгүй тусламжийн хэлэлцээр, ӨТС-гийн буцалтгүй тусламжийн хэлэлцээр, НЗДТГ-ын төслийн гэрээ болон МУХБ-ны төслийн гэрээнд тус тус заасан нөхцөл, болзлын дагуу Зээлдэгчид зээл олгохоор шийдвэрлэсэн.

ИЙМЭЭС талууд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Стандарт нөхцөл; тодорхойлолт

Заалт 1.01. Хуваарь 1-т заасан стандарт нөхцөл("Стандарт нэр томьёо" гэх)-нд тусгагдсан бүхий л заалтууд энэхүү Зээлийн хэлэлцээрт үйлчилнэ.

Заалт 1.02. Стандарт нөхцөл болон Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээрийн заалт 1.02-т тусгагдсан зарим нэр томьёог энэхүү "Зээлийн нөхцөл"-д өөрчлөн тодорхойлоогүй эсхүл тухайн нэг хэсэгт агуулгын хувьд өөр утга илэрхийлээгүй бол тэдгээр нь энэхүү Зээлийн нөхцөлд ижил утгаар хэрэглэгдэнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

ЗЭЭЛ

Заалт 2.01. (а) АХБ нь Зээлдэгчид тус банкны Ногоон уур амьсгалын сангаас ерэн таван сая доллар (\$95,000,000)-ын зээлийг олгоно.

(б) Уг зээлийн үндсэн төлбөрийг төлөх хугацаа гучин (30) жил бөгөөд энэхүү заалтын дэд хэсэг (с)-д тусгасан үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа үйлчилнэ.

(с) Дээрх дэд хэсэг (б)-д заасан "зээлийн үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа" гэж энэхүү зээлийн хэлэлцээрийн Хуваарь 2-т заасан зээлийг эргэн төлөх хуваарийн дагуу үндсэн зээлийг эргүүлэн төлж эхлэх анхны товлосон хугацаа хүртэлх үеийг хэлнэ.

Заалт 2.02. Зээлдэгч нь уг Зээлийг УАНС-гаас АХБ-нд тус сангийн магадлан итгэмжлэгдсэн хэрэгжүүлэгч байгууллагын хувьд олгосон хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлж буйг хүлээн зөвшөөрнө. Стандарт нэр томьёоны заалт 2.02-ын заасанчлан Зээлдэгч нь тухайн хөрөнгийн эх үүсвэр байгаа эсэхээс хамааран Зээлийн хөрөнгө зарлагдах боломжтой.



Заалт 2.03. Зээлдэгч нь Зээлийн данснаас зарлагадаагүй үлдэгдэлд жилийн 0.5%-ийн хөрөнгө баталгаажуулсны төлбөр тогтмол төлнө. Хөрөнгө баталгаажуулсны төлбөр нь Зээлийн хэлэлцээр байгуулсан өдрөөс хойш 60 хоногийн дараагаас авахуулаад Зээлийн данснаас тухайн үеийн үлдэгдлээс Зээлдэгч зарлага хийх эсвэл цуцлах өдөр хүртэл хуримтлагдана.

Заалт 2.04. Зээлдэгч нь АХБ-нд Зээлийн данснаас зарлагадсан болон үлдэгдэл зээлд жилийн 0.25%-ийн үйлчилгээний шимтгэл тогтмол төлнө.

Заалт 2.05. Зээлийн үйлчилгээний шимтгэл болон хөрөнгө баталгаажуулсны төлбөрийг жил бүр 2 дугаар сарын 15 болон 8 дугаар сарын 15-ний өдөр төлнө.

Заалт 2.06. Зээлдэгч нь Зээлийн данснаас зарлагадсан зээлийн үндсэн төлбөрийг энэхүү Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 2-т заасан зээлийг эргэн төлөх хуваарийн дагуу эргүүлэн төлнө.

Заалт 2.07. Зээлийн үндсэн төлбөрийг эргүүлэн төлөх валют, үйлчилгээний шимтгэл болон хөрөнгө баталгаажуулсны төлбөрийг төлөх валют нь Доллар байна.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Зээлийн хөрөнгийг ашиглах

Заалт 3.01. (а) Зээлдэгч нь АХБ-ны шаардлагад нийцэх дамжуулан зээлдэх гэрээний хүрээнд уг зээлийн хөрөнгийг зарим хэсгийг төсөл гүйцэтгэгч байгууллагад дамжуулан зээлдэнэ.

(б) Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийг Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээрийн Хуваарь 5-ын заалтууд, энэхүү Зээлийн хэлэлцээрийн заалтууд, Энгийн үйл ажиллагааны зээлийн хэлэлцээр, УАНС-гийн буцалтгүй тусламжийн гэрээ, ӨТС-гийн буцалтгүй тусламжийн гэрээ, НЗДТГ-ын төслийн гэрээ болон МУХБ-ны төслийн гэрээний дагуу зөвхөн энэхүү Төслийн хүрээнд гарах зардлыг санхүүжүүлэхэд зарцуулах нөхцөлийг хангана.

Заалт 3.02. Зээлийн хөрөнгийг энэхүү Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 3-т заасны дагуу хуваарилж, зарцуулах ба Зээлдэгч, АХБ хоёр харилцан тохиролцсоноор уг Хуваарьт тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Заалт 3.03. АХБ тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд Зээлдэгч зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлыг энэхүү Энгийн үйл ажиллагааны[хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээрт заасны дагуу худалдан авах буюу худалдан авах нөхцөлийг хангана. АХБ нь Зээлдэгч болон тус банкны хооронд харилцан тохиролцсон журмыг ноцтой зөрчин худалдан авалт хийсэн зардал бүхий гэрээг эсхүл гэрээний нөхцөл нь тус банкны шаардлагад нийцэхгүй байх гэрээг санхүүжүүлэхээс татгалзах эрхтэй.

Заалт 3.04. Энэхүү стандарт нөхцөлийн заалт 7.02-ын зорилгоор зээлийг хаах өдөр нь 2027 оны 6 дугаар сарын 30-ны өдөр эсвэл Зээлдэгч болон АХБ шинээр харилцан тохирсон өдөр байна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Тусгай нөхцөл

Заалт 4.01. Зээлдэгч нь Төслийг хэрэгжүүлэх болон Төслийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах явцад Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээр, Энгийн үйл ажиллагааны зээлийн хэлэлцээр, УАНС-гийн буцалтгүй тусламжийн гэрээ, ӨТС-гийн буцалтгүй тусламжийн гэрээ, НЗДТГ-ын төслийн гэрээ болон МУХБ-ны төслийн гэрээнд заасан бүхий л үүргийг биелүүлэх буюу биелүүлэх нөхцөлийг хангана.

Заалт 4.02. Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс НЗДТГ-ын төслийн гэрээ болон МУХБ-ны төслийн гэрээнд тусгагдсан өөрийн үүргийг биелүүлэх нөхцөлөөр хангах ба тэдгээр үүргийг биелүүлэхэд саад болох аливаа алхмыг авч хэрэгжүүлэхгүй эсвэл зөвшөөрөл олгохгүй болно.

Заалт 4.03. Зээлдэгч нь өөрийн болон АХБ-ны ашиг сонирхлыг хамгаалахын сацуу Зээлийн зорилгыг хангах зорилгоор дамжуулан зээлдэх гэрээнд олгогдсон өөрийн эрхийг хэрэгжүүлэх ба материаллаг шинжтэй аливаа өөрчлөлтийг АХБ-тай зөвшилцөнө.

Заалт 4.04. АХБ-ны Зээлийн данснаас хөрөнгө зарлагдах боломжоор хангах үүрэг нь тус банк тухайн хөрөнгийг МИМГ болон СУАГ-ний дагуу УАНС-гаас хүлээн авсан эсэхээр хязгаарлагдана.

Заалт 4.05. Зээлдэгч нь Төсөл, Бараа ба Ажлаас гадна төсөлд хамааралтай аливаа бүртгэл болон баримт бичигт хяналт шалгалт хийх боломжийг АХБ-ны төлөөлөгчдөд олгоно.



ТАВДУГААР ЗҮЙЛ

Эрх түдгэлзүүлэх, зээлийн төлбөр төлөх явцыг хурдасгах

Заалт 5.01. Стандарт нөхцөлийн заалт 7.01(l)-ийн зорилгоор дараах нэмэлт тохиолдолд Зээлийн данснаас зарлага гаргах Зээлдэгчийн эрх түдгэлзэнэ:

(a) Зээлдэгч нь Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээр, Энгийн үйл ажиллагааны зээлийн хэлэлцээр, УАНС-гийн буцалтгүй тусламжийн гэрээ болон ӨТС-гийн буцалтгүй тусламжийн гэрээнд тусгагдсан өөрийн хүлээсэн үүргийг биелүүлээгүй;

(b) Төсөл гүйцэтгэгч байгууллага нь НЗДТГ-ын төслийн гэрээнд тусгагдсан өөрийн хүлээсэн үүргийг биелүүлээгүй;

(c) Төсөл хэрэгжүүлэгч агентлаг нь МУХБ-ны төслийн гэрээнд тусгагдсан өөрийн хүлээсэн үүргийг биелүүлээгүй; мөн

(d) УАНС-гийн буцалтгүй тусламж эсхүл ӨТС-гийн буцалтгүй тусламжийг түдгэлзүүлэх эсвэл цуцлах нөхцөлд хүрсэн.

Заалт 5.02. Стандарт нөхцөлийн заалт 7.07 (d)-ийн зорилгоор дараах тохиолдолд зээлийг эргэн төлөх хугацааг хурдасгах нөхцөл үүссэн гэж үзнэ: Зээлийн хэлэлцээрийн 5.01 заалтад тусгагдсан аливаа нөхцөл байдал үүсэх тохиолдолд.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Хүчин төгөлдөр болох

Заалт 6.01. Стандарт нөхцөлийн 8.01(c) заалтын хүрээнд энэхүү Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болгоход дараах нэмэлт нөхцөл хангагдсан байна:

(a) Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээрийг зохих ёсоор үйлдэж, хүргүүлсний дээр түүнийг хүчин төгөлдөр болгоход тавигдаж буй (энэхүү Зээлийн хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардагдаж буй нөхцөлөөс бусад) бүхий л урьдчилсан нөхцөл хангагдсан байх;

(b) Энгийн үйл ажиллагааны зээлийн хэлэлцээрийг зохих ёсоор үйлдэж, хүргүүлсний дээр түүнийг хүчин төгөлдөр болгоход тавигдаж буй



(энэхүү Зээлийн хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардагдаж буй нөхцөлөөс бусад) бүхий л урьдчилсан нөхцөл хангагдсан байх;

(c) УАНС-гийн буцалтгүй тусламжийн гэрээг зохих ёсоор үйлдэж, хүргүүлсний дээр түүнийг хүчин төгөлдөр болгоход тавигдаж буй (энэхүү Зээлийн хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардагдаж буй нөхцөлөөс бусад) бүхий л урьдчилсан нөхцөл хангагдсан байх; мөн

(d) ӨТС-гийн буцалтгүй тусламжийн гэрээг зохих ёсоор үйлдэж, хүргүүлсний дээр түүнийг хүчин төгөлдөр болгоход тавигдаж буй (энэхүү Зээлийн хэлэлцээрийг болгоход шаардагдаж буй нөхцөлөөс бусад) бүхий л урьдчилсан нөхцөл хангагдсан байх.

Заалт 6.02. Стандарт нөхцөлийн 8.02 заалтын хүрээнд АХБ-нд ирүүлэх дүгнэлт эсвэл дүгнэлтүүдэд тусгасан байх шаардлагатай нэмэлт зүйлс болно:

(a) Зээлдэгчийг төлөөлж Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээрийг зохих ёсоор баталж эсвэл соёрхон баталж, үйлдэж, хүргүүлэх ба уг хэлэлцээр нь түүнд тусгагдсан нөхцөлийн хүрээнд хуулийн дагуу Зээлдэгчид хүчин төгөлдөр үйлчлэх болсон;

(b) Зээлдэгчийг төлөөлж Энгийн үйл ажиллагааны зээлийн хэлэлцээрийг зохих ёсоор баталж эсвэл соёрхон баталж, үйлдэж, хүргүүлэх ба уг хэлэлцээр нь түүнд тусгагдсан нөхцөлийн хүрээнд хуулийн дагуу Зээлдэгчид хүчин төгөлдөр үйлчлэх болсон;

(c) Зээлдэгчийг төлөөлж УАНС-гийн буцалтгүй тусламжийн гэрээг зохих ёсоор баталж эсвэл соёрхон баталж, үйлдэж, хүргүүлэх ба уг хэлэлцээр нь түүнд тусгагдсан нөхцөлийн хүрээнд хуулийн дагуу Зээлдэгчид хүчин төгөлдөр үйлчлэх болсон; мөн

(d) Зээлдэгчийг төлөөлж ӨТС-гийн буцалтгүй тусламжийн гэрээг зохих ёсоор баталж эсвэл соёрхон баталж, үйлдэж, хүргүүлэх ба уг хэлэлцээр нь түүнд тусгагдсан нөхцөлийн хүрээнд хуулийн дагуу Зээлдэгчид хүчин төгөлдөр үйлчлэх болсон.

Заалт 6.03. Стандарт нөхцөлийн 8.04 заалтын хүрээнд энэхүү Зээлийн хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.



ДОЛДУГААР ЗҮЙЛ

Бусад

Заалт 7.01. Стандарт нөхцөлийн заалт 10.02-ын зорилгоор Зээлдэгч талын төлөөлөгч нь Зээлдэгчийн Сангийн сайд байна.

Заалт 7.02. Стандарт нөхцөлийн заалт 10.01 заалтын зорилгоор дараах албан ёсны хаягийг ашиглана. Үүнд:

Зээлдэгчийн хувьд

Сангийн яам
С.Данзангийн гудамж 5/1
Засгийн газрын II байр
Улаанбаатар-15160
Монгол улс
Факс: (976-51) 267468

АХБ-ны хувьд

Азийн Хөгжлийн Банк
Азийн Хөгжлийн Банкны өргөн чөлөө 6
Мандалуйонг хот
1550 Метро Манила
Филиппин Улс
Факс: (632) 636-2444
(632) 636-2407.

ЭНД ӨГҮҮЛСНИЙГ НОТЛОН, талууд зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчдөөрөө дамжуулан хэлэлцээрийн эхэнд дурдсан өдөр энэхүү Зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурж, АХБ-ны Төв байранд хүргүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛЖ АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

Ч.ХҮРЭЛБААТАР
Сайд
Сангийн яам

ЁЛАНДА ФЕРНАНДЕЗ ЛОММЕН
Монгол Улсыг хариуцсан захирал
Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар

ХУВААРЬ 1

Стандарт нөхцөл

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Нэр томьёо; Хэрэглэх утга

Заалт 1.01. **Нэр томьёо.** Энэхүү Стандарт нөхцөлд тусгагдсан дараах нэр томьёо нь тухайн нэг хэсэгт агуулгын хувьд өөр утга илэрхийлээгүй бол дор дурдсан утгыг илэрхийлнэ: Нэр томьёо; Хэрэглэх утга

(a) “АХБ-ны Уур амьсгалын ногоон сан” гэж УАНС-гаас тус сангийн хөрөнгийг АХБ хүлээн авч, итгэмжлэн эзэмшиж, захиран зарцуулах зорилгоор тус банкнаас байгуулсан итгэлцлийн санг;

(b) “хөрөнгө” гэж эд хөрөнгө, орлого болон нэхэмжлэх боломжтой бусад төрлийн хөрөнгийг;

(c) “Хөрөнгө баталгаажуулсны төлбөр” гэж энэхүү Зээлийн хэлэлцээрийн заалт 2.03-т тусгасан менежментийн төлбөрийг;

(d) “хөрвөх валют” гэж АХБ-наас тийнхүү зарласан аливаа валютыг;

(e) “аль нэг орны эсвэл газар нутгийн “валют” гэж тухайн улс орон эсвэл газар нутагт төрийн болон хувийн хэвшлийн өр төлбөр төлөхөд хэрэглэдэг хууль ёсны мөнгөн тэмдэгтийг;

(f) “Доллар” эсхүл “\$” тэмдэг гэж аль аль нь Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг;

(g) “Хүчин төгөлдөр болох өдөр” гэж энэхүү Хуваарь 1-ийн 8.03 заалтын дагуу Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болж үйлчилж эхлэх өдрийг;

(h) “гадаад валют” гэж өөрийн газар нутагт Төслийг хэрэгжүүлж буй гишүүн орны үндэсний валютаас бусад валютыг;

(i) “Уур амьсгалын ногоон сан” эсхүл “УАНС” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн хүрээнд байгуулагдаж, Удирдах байгууллагад захирагдах санг;



(j) “баталгаа” гэж тухайн нөхцөлд баталгаа, сөрөг-баталгаа эсвэл нөхөн төлбөрийн зорилгыг хангах, гишүүн орноос АХБ-нд зориулан, түүнийг хүлээн авагчаар тодорхойлон гаргах аливаа сөрөг-баталгаа эсвэл нөхөн төлбөр болон бусад зохицуулалтыг;

(к) “барьцаа” гэж ипотека, барьцаа, төлбөр болон тусгай эрх болон бусад төрлийн давуу эрхийг;

(l) “Зээл” гэж энэхүү Зээлийн хэлэлцээрээр олгогдох зээлийг;

(m) “Зээлийн данс” гэж АХБ-наас Зээлдэгчийн нэрэн дээр нээх эсвэл нээсэн, зээлийн хөрөнгийг байршуулах эсвэл байршуулсан дансыг;

(n) “Зээл хаах өдөр” гэж Зээлийн хэлэлцээрийн зээл эргэн төлөх хуваарьт тусгагдсан эхний Зээлийн үндсэн төлбөр хийгдэхээс өмнөх АХБ-наас тогтоосон өдөр эсхүл энэхүү зорилгоор АХБ болон Зээлдэгч харилцан тохиролцсон өөр нэг өдрийг;

(o) “Зээлийн валют” гэж тухай бүр Зээлийн үндсэн хөрөнгийг илэрхийлэх валютыг;

(p) “гишүүн орон” гэж АХБ-ны гишүүн орныг;

(q) “Зээлийн үндсэн төлбөр төлөх өдөр” гэж Зээлийн үндсэн төлбөрийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн төлөхөөр Зээлийн хэлэлцээрт тусгасан өдрийг;

(r) “үйлчилгээний шимтгэл” гэж Зээлийн хэлэлцээрийн 2.04 заалтын дагуу Зээлд төлөх шимтгэлийг; мөн

(s) “татвар” гэж Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болоход үйлчилж буй эсвэл ирээдүйд шинээр нэвтрүүлэх аливаа төрлийн татвар, хураамж, төлбөр болон хураамжийг тус тус хэлнэ.

Заалт 1.02. Хэрэглэх утга. Тухайн нэг хэсэгт агуулгын хувьд өөр утга илэрхийлэгдээгүй бол, (a) өр үүсэх гэдэгт өр шилжүүлэн авах болон өрийн баталгааг хамааруулан ойлгоно; (b) энэхүү Стандарт нөхцөлд зүйл, заалт гэж дурдсан бол энэхүү Стандарт нөхцөлд тусгагдсан зүйл, заалтыг хэлнэ; (c) зүйл, заалтын гарчгийг ашиглахад хялбар болгох үүднээс оруулсан боловч тэдгээр нь Стандарт нөхцөлийг бүрэлдүүлэх агуулгад тооцогдохгүй болно; (d) нэг тоо нь олон тоог, олон тоо нь нэг тоог илэрхийлж болно; мөн (e) аливаа хүйсийг төлөөлүүлэн ашигласан үг нь эсрэг хүйсийг илэрхийлж болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Зээлийн данс; Үйлчилгээний шимтгэл; Хөрөнгө баталгаажуулсны төлбөр; Эргэн төлөлт; Төлбөрийн байршил

Заалт 2.01. **Зээлийн данс.** Зээлийн үндсэн хөрөнгийг тухайн Зээлийн валютаар Зээлийн дансанд орлогодох ба түүний дараа энэхүү Зээлийн хэлэлцээрт заасан заалтуудын дагуу зарлагдаж болно.

Заалт 2.02. **Санхүүжилтийн дутагдал.** 2.01 заалтаас үл хамааран, Зээлийн данснаас зарлагдах аливаа дүн нь АХБ-ны Зээлийн зорилгоор өөрт олгогдсон хөрөнгө нөөцөөс боломжтой болгосон дүнгээс хэтрэх тохиолдолд тухайн зарлага хийгдэхгүй болно. АХБ нь зөвхөн Зээлийн зорилгоор өөрт олгогдсон хөрөнгө нөөцийн хүрээнд хязгаарлагдан энэхүү Зээлтэй холбоотой үүрэг, нэхэмжлэл эсвэл хариуцлагыг хүлээх боломжтой.

Заалт 2.03. **Үйлчилгээний шимтгэл.** Зээлийн данснаас зарлагдсан болон үлдэгдэл Зээлийн үндсэн хөрөнгөнд энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгагдсан хувь хэмжээ бүхий үйлчилгээний шимтгэлийг тухай бүр төлнө. Үйлчилгээний шимтгэл нь Зээлийн данснаас зарлага хийгдсэн тухайн өдрүүдээс эхлэн хуримтлагдана. АХБ нь үйлчилгээний шимтгэл төлөгдөх өдөр Зээлдэгчийг төлөөлж Зээлийн данснаас шимтгэлийг зарлагдаж, өөрөө өөртөө төлөх эрхтэй.

Заалт 2.04. **Хөрөнгө баталгаажуулсны төлбөр.** Зээлдэгч нь энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгагдсан хэмжээгээр энэхүү хөрөнгө баталгаажуулсны төлбөрийг АХБ-нд төлнө. Хэрэв энэхүү Зээлийн хэлэлцээрт хөрөнгө баталгаажуулсны төлбөрийг Зээлийн хөрөнгөөс төлөхөөр заасан бол АХБ нь Зээл хүчин төгөлдөр болох өдөр эсхүл түүний дараа Зээлдэгчийг төлөөлөн Зээлийн данснаас тухайн хөрөнгө баталгаажуулсны төлбөрийг зарлагадан, өөрөө өөртөө төлнө.

Заалт 2.05. **Үйлчилгээний шимтгэл болон бусад төлбөрийг тооцох нь.** Хэрэв Зээлдэгч нь үйлчилгээний шимтгэл болон Үүрэг хүлээсний төлбөрийг бүхэл дүнгээр биш Зээлийн зарлагдаагүй дүн дээр жилийн хувь хэмжээнд тооцоолон жилд хоёр удаа төлөхөөр шийдвэл тухайн Үүрэг хүлээсний төлбөрийг 30 хоногтой 12 сар буюу жилийн 360 хоног дээр үндэслэн тооцоолно.

Заалт 2.06. **Эргэн төлөх ба урьдчилан төлөх.** (а) Зээлдэгч нь Зээлийн данснаас зарлагдсан үндсэн зээлийн дүнг энэхүү Зээлийн хэлэлцээрийн заалт болон зээлийг эргэн төлөх хуваарийн дагуу АХБ-нд эргүүлэн төлнө.



(b) Зээлдэгч нь АХБ-нд 45-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэл хүргүүлж, зээл дуусах хугацаанаас өмнө АХБ-наас зөвшөөрсөн өдөрт багтаан (Зээлдэгч нь энэхүү Зээлийн хэлэлцээрт хамааралтай тухайн үеийн үлдэгдэл дүнг бүхэлд нь төлөх боломжтой тохиолдолд) (i) тухайн үеийн Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийг бүхэлд нь; эсвэл (ii) Зээлийн дуусах хугацааг нэг эсвэл хэд хэдээр хэсэгчлэн сонгож түүнд ногдох үндсэн төлбөрийг бүхэлд нь урьдчилан төлөх эрхтэй.

(c) Хэрэв АХБ нь Зээлдэгчээс (i) энэхүү Зээлийн хэлэлцээрийн дагуу тухайн үед төлөгдөх ёстой дүнгээс бага дүнтэй; эсвэл (ii) энэхүү заалтын (b) хэсэгт заасан АХБ-нд төлөх ёстой дүнгээс бага дүнтэй төлбөр хүлээн авбал, тус банк нь тухайн дүнг өөрийн хүлээн авсан байдлаар хуваарилж, хасалт хийх эсэхийг өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдэх эрхтэй.

Заалт 2.07. Төлбөрийн байршил. Зээлийн үндсэн төлбөр, үйлчилгээний шимтгэл болон бусад төлбөр (үүнд Үүрэг хүлээсний төлбөр орно)-ийг АХБ-ны хүсэмжилсэн газар төлж, байршуулна.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Валютын заалтууд

Заалт 3.01. Зарлага хийх валют. Зээлийн данснаас зарлага хийх валют нь Зээлийн валют байна.

Заалт 3.02. Төлбөрийн валют. Зээлийн үндсэн төлбөр, Зээлийн аливаа хэсэгт ногдох үйлчилгээний шимтгэл болон Үүрэг хүлээсний төлбөрийг Зээлийн валютаар хийнэ.

Заалт 3.03. Валют худалдан авах. Хэрэв Зээлдэгч нь АХБ-ны шаардлагад нийцсэн өөр нэг валютаар цаг тухайд нь хангалттай хэмжээнд хөрөнгө гаргаж өгсөн тохиолдолд АХБ нь Зээлдэгчийн хүсэлтээр тус банкны нөхцөлд нийцүүлэн, үндсэн төлбөрийн эргэн төлөлт, үйлчилгээний шимтгэл болон Үүрэг хүлээсний төлбөрийг төлөх зорилгоор Зээлийн валют худалдан авч өгч болно. Гэсэн хэдий ч үүнийг үл харгалзан АХБ нь зөвхөн Зээлийн валютаар тухайн төлбөрийг зохих хэмжээнд авмагц Зээлдэгч энэхүү Зээлийн хэлэлцээрийн дагуу хийх төлбөрийн үүрэг хангагдсан гэж тооцно.

Заалт 3.04. Валютын үнэлгээ. Энэхүү Зээлийн хэлэлцээрийн хүрээнд нэг валютыг өөр нэг валютаар үнэлэх шаардлага үүсэх тохиолдолд АХБ-наас зохистой гэж үзсэн утгыг ашиглана.

Заалт 3.05. **Төлбөрийн хэлбэр.** (а) Энэхүү Зээлийн хэлэлцээрийн дагуу АХБ-нд төлөх шаардлагатай аливаа төлбөрийг аль нэг орны валютаар хийх бол тухайн орны тийнхүү төлбөр хийхэд тавигдах хуулийн дагуу авч, төлбөрийг тухайн оронд байрших АХБ-ны дансанд шилжүүлж, байршуулна.

(b) Зээлдэгч нь Зээлийн үндсэн төлбөр, үйлчилгээний шимтгэл болон бусад төлбөрийг төлөхдөө өөрийн орны газар нутагт тавигдах аливаа хязгаарлалтыг хэрэглэлгүй төлнө.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Зээлийн хөрөнгийг ашиглах

Заалт 4.01. **Зээлийн данснаас зарлагадах.** (а) Зээлийн хөрөнгийг зөвхөн Төслийн зорилгоор ашиглана. Зээлдэгч нь энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгагдсан аливаа нөхцөл болон хязгаарлалтаас харгалзан, гүйцэтгэх шаардлагатай төлбөрийн зорилгоор эсхүл АХБ-наас зөвшөөрсний дагуу тухайн дүнгээр Төсөлд шаардлагатай бөгөөд энэхүү Зээлийн хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэхээр заасан бараа, үйлчилгээ болон бусад зардлын төлбөрийг гүйцэтгэх зорилгоор Зээлийн данснаас хөрөнгө зарлагадах эрхтэй. Хэрэв АХБ нь Зээлийн данснаас зарлагадсан аливаа хөрөнгийг Зээлдэгч энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгасан зорилгоор ашиглаагүй гэж үзвэл Зээлдэгч нь тухайн дүн бүхий хөрөнгийг АХБ-нд нэн даруй буцаан олгоно.

(b) АХБ, Зээлдэгч өөрөөр харилцан тохиролцоогүй бол Хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө гарсан зардлыг санхүүжүүлэх аливаа зарлага хийгдэхгүй болно. АХБ нь тус банк болон Зээлдэгч хооронд харилцан тохиролцсон процедурыг илтэд зөрчин худалдан авсан бүтээгдэхүүн үйлчилгээ бүхий гэрээг эсхүл АХБ-ны шаардлагад нийцэхгүй нөхцөл бүхий гэрээг санхүүжүүлэхээс татгалзаж болно. Хэрэв АХБ нь Зээлдэгчийг ийм гэрээг санхүүжүүлэхээр Зээлийн данснаас уг Зээлийн хөрөнгийг зарлагадсан гэж үзвэл Зээлдэгч нь тухайн дүн бүхий хөрөнгийг АХБ-нд нэн даруй буцаан олгоно.

(c) Зээлийн хөрөнгийг Зээлийн данснаас Зээлийн валютаар зарлагадна. АХБ нь Зээлдэгчийн хүсэлтээр түүнийг төлөөлөх этгээд болж, тус банкны тогтоосон нөхцөлийн дагуу Зээлийн данснаас зарлагадсан валютыг ашиглан Зээлдэгчийн уг Зээлээс санхүүжүүлэх зардлын төлбөрийг хангах хүсэлтийг биелүүлэх зорилгоор түүний хүссэн бусад валют худалдан авч болно. Энэхүү Зээлийн хэлэлцээрийн хүрээнд нэг валютыг өөр нэг валютаар үнэлэх шаардлага үүсэх тохиолдолд АХБ-наас зохистой гэж үзсэн утгыг ашиглана.



Заалт 4.02. **АХБ-ны баталгааны бичиг.** Дараа нь түдгэлзэх эсхүл цуцлах эсэхээс үл хамааран АХБ нь Зээлдэгчийн хүсэлтээр Зээлийн хүрээнд санхүүжүүлэх бараа, үйлчилгээний зардлыг төлөх дүнгээр баталгааны бичиг гаргаж болно.

Заалт 4.03. **Зарлагын хүсэлт.** Зээлдэгч нь Зээлийн данснаас аливаа дүнгээр зарлага гаргах эсхүл 4.02 заалтын дагуу баталгааны бичиг гаргуулах хүсэлт тавихдаа тус банкны шаардах агуулга, төлөөлөл, баталгаа болон гэрээг агуулах өргөдлийн маягтыг ашиглан хүсэлт гаргана. АХБ болон Зээлдэгч өөрөөр харилцан тохиролцоогүй тохиолдолд энэхүү зүйлд заасан зарлагын хүсэлт, түүнд хавсаргах шаардлагатай баримт бичгүүдийг Төслийн зардалтай холбогдуулан нэн даруй ирүүлнэ.

Заалт 4.04. **Хүсэлтэд гарын үсэг зурах эрх мэдлийн нотолгоо.** Зээлдэгч нь АХБ-нд зарлагын хүсэлтэд гарын үсэг зурах этгээдэд тухайн эрх мэдлийг олгосон болохыг нотлох баримт бичиг болон тухайн албан тушаалтан бүрийн баталгаат гарын үсгийг АХБ-нд ирүүлнэ.

Заалт 4.05. **Дагалдах нотолгоо.** Зээлдэгч нь зарлагын хүсэлтийг АХБ-наас тавьсан шаардлагын дагуу дагалдах нотолгоо бүхий баримт бичгийн хамт АХБ тухайн хүсэлтэд тусгасан зарлагыг зөвшөөрөхөөс өмнө эсвэл дараа аль нэгэнд тус банкинд ирүүлнэ.

Заалт 4.06. **Хүсэлт болон баримт бичгүүдийн бүрэн бүтэн байдал.** Зарлагын хүсэлт бүр, түүний дагалдах баримт бичиг, бусад нотолгоо нь хэлбэр, агуулгын хувьд Зээлдэгч Зээлийн данснаас тухайн дүнгээр зарлага хийх эрхтэй бөгөөд зарлагадсан хөрөнгө нь зөвхөн энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгасан зорилгоор ашиглагдах болно гэж АХБ-наас үзэхүйц хэмжээнд хангалттай байх шаардлагатай.

Заалт 4.07. **АХБ-наас төлбөр төлөх.** Зээлдэгчийн Зээлийн данснаас авах эрхтэй хөрөнгийг АХБ өөрөө эсвэл Зээлдэгчийн зааварчилгаар төлнө.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Тусгай нөхцөл

Заалт 5.01. **Хамтын ажиллагаа ба мэдээлэл.** (а) АХБ болон Зээлдэгч нь Зээлийн зорилгыг хангах үүднээс бүрэн хамтран ажиллана. Иймд, АХБ болон Зээлдэгч нь:

(i) аль нэг талын хүсэлтээр Төслийн ахиц, Зээлийн зорилго болон энэхүү Зээлийн хэлэлцээрийн үйлчилгээг хадгалахтай [Төслийн гүйцэтгэгч



агентлагийн үүргийг хангуулахтай] холбогдуулан харилцан санал солилцох, нэг талын хүсэмжилсэн мэдээллийг нөгөө тал гаргаж өгөх; мөн

(ii) энэхүү заалтын (a)(i) хэсэгт тусгагдсан асуудалтай зөрчилдөх эсвэл зөрчилдөх эрсдэл үүсгэж буй аливаа нөхцөл байдлын талаар харилцан мэдэгдэх.

(b) Зээлдэгч нь өөрийн нутаг дэвсгэрт АХБ-ны төлөөлөгчийг Зээлтэй холбогдуулан айлчлал хийх зохистой бүхий л боломжоор хангана.

Заалт 5.02. Үл барьцаалах нөхцөл. (a) Хэрэв зээлдэгч нь өөрийн хөрөнгийг аливаа гадаад валютын өрийн барьцаанд тавьж, барьцааны эрх үүсгэх тохиолдолд тэрээр тухайн барьцааны эрх нь Зээлийн үндсэн төлбөр, үйлчилгээний шимтгэлийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд үнэлэгдэхүйц байлгана. Хэрэв Зээлдэгчийн (энд тодорхойлсончлон) аливаа хөрөнгийг гадаад валютын өрийн барьцаа болгон хууль ёсны барьцааны эрх үүсэх тохиолдолд Зээлдэгч нь АХБ-нд шаардлагад нийцэх, ижил барьцааны эрх олгоно.

(b) Энэхүү заалтын (a) хэсэг нь дараахад хамаарахгүй болно: (i) худалдан авах үед, зөвхөн тухайн эд хөрөнгийн худалдан авах үнийг төлөх барьцаа болгон үүссэн эд хөрөнгийн барьцааны эрх нь; эсхүл (ii) банкны ердийн хэлцэл, гүйлгээний үед үүсэх, тухайн үеэс хойш нэг жилийн хугацаатай өр бий болгох барьцааны эрх.

(c) Энэхүү заалтын (a) хэсэгт дурдсан “Зээлдэгчийн хөрөнгө”-нд Зээлдэгчийн орон нутгийн засаг захиргааны эсхүл аливаа агентлагийн хөрөнгө, тухайн орон нутгийн засаг захиргааны агентлагийн хөрөнгө болон Зээлдэгчийн эсхүл түүний орон нутгийн засаг захиргаа, агентлаг (үүнд Зээлдэгчийн төв банкны үүрэг гүйцэтгэх аливаа байгууллага орно)-ийн өмчлөл, хяналтад байдаг, түүний нэрийн өмнөөс үйл ажиллагааг явуулдаг, түүнд ашиг хүртээдэг байгууллагуудын хөрөнгийг хамруулан ойлгоно.

Заалт 5.03. Даатгал. (a) Зээлдэгч нь хариуцлагатай даатгагчийг үйлчилгээ авч, түүнийгээ хадгалах эсхүл АХБ-ны шаардлагад нийцэх бусад зохицуулалт хийж зохистой практикт тооцогдох аливаа эрсдэлийн эсрэг, зохих дүнтэй даатгалд хамрагдана. Хэрэв Төсөлд тусгайлсан даатгал байхгүй бол Зээлдэгч нь бие даан даатгуулах сонголт хийсэн гэж үзнэ.

(b) Дээрх ерөнхий заалтад ямар нэгэн хязгаарлалт үзүүлэхгүйгээр, Зээлдэгч нь Зээлийн хөрөнгөөс санхүүжигдэх Төслийн хүрээнд импортлох бүтээгдэхүүнийг хүлээлгэн авах, тээвэрлэх, мөн суурилуулах эсхүл ашиглах газар хүргэж өгөхтэй холбоотой эрсдэлийн даатгалд хамруулах



эсхүл хамруулах нөхцөлөөр хангах ба ийм даатгалын нөхөн төлбөр нь тухайн барааг солих эсхүл засварлахад чөлөөтэй ашиглах валютаар хийгдэнэ.

Заалт 5.04. Бүртгэл, санхүүгийн тайлан ба аудит. Зээлдэгч нь Төслийн хүрээнд санхүүжүүлэх бараа, үйлчилгээ болон бусад зардлыг тодорхойлох; Төслийн ахицыг баримтжуулах (үүнд зардал хамаарна); санхүүгийн зохистой тайлагналын зарчмын дагуу Төслийн үйл ажиллагаа болон санхүүгийн нөхцөл байдлыг тусгах; мөн санхүүгийн тайланг аудитын шалгалтаар оруулах зорилгоор хангалттай хэмжээний бүртгэл, санхүүгийн тайлан хөтлөх эсхүл хөтлөх нөхцөлөөр хангана. Холбогдох шаардлагуудыг Зээлийн хэлэлцээрт тусгана.

Заалт 5.05. Тайлан. (a) Зээлдэгч нь (i) Зээл, зээлийн хөрөнгийн зардал, үйлчилгээ ашиглалт; (ii) Зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ болон бусад зардал; (iii) Төсөл болон Төслийн гүйцэтгэгч агентлаг; (iv) Зээлдэгчийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа болон санхүүгийн нөхцөл байдал; мөн (v) Зээлийн хүрээнд хамааралтай гэх бусад асуудалтай АХБ-наас хүсэмжилсэн тайланг гаргаж өгөх эсхүл гаргуулах нөхцөлөөр хангана.

(b) Зээлдэгч нь Төслийн ахиц, Зээлийн хэлэлцээрт хүлээсэн өөрийн үүргийн гүйцэтгэл, Зээлийн зорилго хангалт эсхүл үйлчилгээний ашиглалтад саад болж буй эсвэл саад болох эрсдэл үүсгэж буй нөхцөл байдлын талаар АХБ-нд нэн даруй мэдэгдэнэ. Мөн Зээлдэгч нь Зээлдэгч болон түүний хөрөнгийн өмчлөл эсхүл хяналтад оруулахаар зэхэж буй аливаа өөрчлөлт, эсвэл ийм үр дүнд хүргэх буюу хүргэх магадлалтай аливаа хэлцэл эсвэл зохицуулалтын талаар нэн даруй АХБ-нд мэдэгдэнэ.

(c) Дээрх ерөнхий заалтад ямар нэгэн хязгаарлалт үзүүлэхгүйгээр, Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэл, АХБ болон Зээлдэгчийн харилцан тохиролцсон зорилт болон арга хэмжээний хангалт, Төслийн барилга байгууламжийн ашиглалт, менежменттэй холбоотой тогтмол тайлангуудыг АХБ-нд ирүүлнэ. Уг тайлангуудыг АХБ-ны хүсэмжилсэн давтамж, хэлбэр, дэлгэрэнгүй байдлын шаардлагад нийцүүлэн ирүүлэх ба тэдгээрт тухайн үнэлгээний явцад тодорхойлсон ахиц дэвшил, хүндрэл бэрхшээл, тэдгээрийг засаж залруулахаар авч хэрэгжүүлсэн болон төлөвлөсөн алхмууд, дараагийн хугацаанд санал болгож буй хөтөлбөрийн үйл ажиллагаа болон хүлээгдэж буй ахиц дэвшил гэх зэргийн талаар тусгана.

(d) Зээлдэгч нь Төслийн хэрэгжилт дуусмагц, ямар ч нөхцөлд энэхүү өдөр эсхүл АХБ болон Зээлдэгч хооронд харилцан тохиролцсон өөр нэг өдрөөс хойш гурван сарын дотор зардал, Зээлийн хэлэлцээрт өөрийн хүлээсэн үүргийн биелэлт, Зээлийн зорилгын хангалт гэх зэрэг

асуудлыг тусгасан Төслийн гүйцэтгэл, эхэн үеийн үйл ажиллагааны тайланг тус банкнаас хүсэмжилсэн хэлбэр, дэлгэрэнгүй байдлын шаардлагад нийцүүлэн бэлтгэж, АХБ-инд хүргүүлнэ.

Заалт 5.06. Зээлдэгчийн үүрэг ба газар чөлөөлөлт. Зээлдэгч нь Зээлийн хөрөнгөөс гадна Төслийг хэрэгжүүлэх болон Төслийн барилга байгууламжийг ашиглах, засаж үйлчлэх зорилгоор шаардагдах санхүүжилт, барилга байгууламж, үйлчилгээ, газар болон бусад хүч нөөцийг шаардлагатай үед нэн даруй хойшлуулшгүйгээр гаргана. Зээлдэгч нь Төслийн хүрээнд ашиглах эдгээр санхүүжилт, барилга байгууламж, үйлчилгээ, газар болон бусад хүч нөөц гаргахад бэлэн гэдгийг нотлох нотолгоог АХБ-ны хүсэлтээр түүнд нэн даруй тус банкны шаардлагад нийцсэн байдлаар гаргаж өгнө.

Заалт 5.07. Ажлын хуваарь, төлөвлөгөө болон дизайны стандарт. Зээлдэгч нь төслийг Зээлдэгч болон АХБ-ны шаардлагад нийцсэн холбогдох төлөвлөгөө, дизайны стандарт, тодорхойлолт, ажлын хуваарь болон барилгын арга техник ашиглан хэрэгжүүлэх нөхцөлөөр хангана. Зээлдэгч нь АХБ-наас шаардлага тавих тохиолдолд төлөвлөгөө, дизайны стандарт, тодорхойлолт, ажлын хуваарийг анх боловсруулагдсаны дараа болон аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах бүрд АХБ-ны шаардлагад нийцсэн дэлгэрэнгүй байдлаар тус банкинд ирүүлэх эсхүл ирүүлэх нөхцөлөөр хангана.

Заалт 5.08. Ерөнхий ажиллагаа. (а) Зээлдэгч нь Төслийг зохих журмын дагуу, үр ашигтай мөн санхүү, бизнес болон хөгжлийн практикийг баримтлан хэрэгжүүлэх нөхцөлөөр хангана. Зээлдэгч нь АХБ-тай хамтаар Төслийг тус банкны авилгын эсрэг, хөдөлмөрийн суурь стандарт, байгаль орчин болон нийгмийн хамгаалал, жендэр, худалдан авах ажиллагаа ба зөвлөх үйлчилгээ, зарцуулалтын талаарх болон энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгагдсан бусад бодлогыг баримтлан хэрэгжүүлэх нөхцөлөөр хангана.

(b) Зээлдэгч нь Төслийг хэрэгжүүлэх, Төслийн барилга байгууламжийг ажиллуулахтай холбоотой оролцох өөрийн яам, агентлагийн үйл ажиллагааг захиргааны зохистой бодлого, процедурын дагуу явуулах нөхцөлөөр хангана.

Заалт 5.09. Гэрээт гүйцэтгэгч болон зөвлөх. Зээлдэгч нь Төслийг хэрэгжүүлэхдээ Зээлдэгч болон АХБ-ны шаардлагад нийцсэн ур чадвартай, мэргэжлийн зөвлөх, гэрээт гүйцэтгэгчдийг хоёр талын тавьж буй нөхцөл, хэр хэмжээнд нийцүүлэн авч ажиллуулна.

Заалт 5.10. Засвар үйлчилгээ. Зээлдэгч нь Төсөлтэй холбоотой аливаа барилга байгууламжийг ашиглалт болон засвар



үйлчилгээний зохистой практикийн дагуу ашиглаж, засварлах ба үйлчилнэ. Зээлдэгч нь шаардлагатай үед нэн даруй бүхий л хэрэгтэй засвар, шинэчлэлийг хийж, хэрэгжүүлнэ.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Татвараас чөлөөлөх

Заалт 6.01. **Татвараас чөлөөлөх.** Зээлдэгч нь дараах нөхцөлийг хангана:

(a) Зээлийн үндсэн төлбөр, үйлчилгээний шимтгэл болон бусад төлбөр (үүнд Үүрэг хүлээсний төлбөр багтана)-ийг өөрийн улсаас ногдуулсан эсвэл газар нутагт мөрдөгдөж буй аливаа татвараас чөлөөлж, ямар нэгэн суутгалгүй төлнө; мөн

(b) Энэхүү Зээлийн хэлэлцээр болон Төслийн гэрээг үйлдэх, хүргэх болон бүртгүүлэхэд хамааралтай өөрийн улсаас ногдуулсан эсвэл газар нутагт мөрдөгдөж буй аливаа татвараас чөлөөлнө.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

Гэрээг түдгэлзүүлэх; цуцлах; зээл төлөх хугацааг хурдасгах

Заалт 7.01. **АХБ-наас түдгэлзүүлэх.** Энэхүү Зээлийн хэлэлцээрийн өдрөөс хойш дараах тохиолдлуудын аль нэг үүсэж, үргэлжилсэн хэвээр байвал АХБ-ны зүгээс мэдэгдэл өгч, Зээлийн данснаас зарлага хийх Зээлдэгчийн эрхийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно:

(a) Зээлдэгч нь (i) Зээлийн хэлэлцээрт тусгагдсан; эсхүл (ii) АХБ-тай байгуулсан бусад зээлийн хэлэлцээр эсвэл баталгааны гэрээнд тусгагдсан; эсхүл (iii) Зээлдэгчтэй гэрээ байгуулан АХБ-наас аливаа баталгаа эсхүл бусад санхүүгийн үүрэг хүлээх хэлцэл хийсний үр дүнд төлөх үүрэг хүлээсэн үндсэн төлбөр, үйлчилгээний шимтгэл эсхүл аливаа бусад төлбөр (үүнд Үүрэг хүлээсний төлбөр орно)-ийг төлөөгүй.

(b) Зээлдэгч нь энэхүү Зээлийн хэлэлцээрийн хүрээнд өөрийн хүлээсэн бусад үүргийг биелүүлээгүй.

(c) Төсөл гүйцэтгэгч агентлаг нь энэхүү Зээлийн хэлэлцээрийн хүрээнд өөрийн хүлээсэн аливаа үүргийг биелүүлээгүй.



(d) АХБ нь Зээлдэгчтэй байгуулсан аль нэг өөр зээлийн хэлэлцээрийн хүрээнд Зээлдэгч тус зээлийн хэлэлцээр эсхүл баталгааны гэрээнд хүлээсэн аль нэг үүргээ биелүүлээгүй гэх үндэслэлээр Зээлдэгчийн зарлага хийх эрхийг бүхэлд нь болон хэсэгчлэн түдгэлзүүлсэн.

(e) АХБ-ны өөрийн зохих ёсны дүгнэлтээр (i) Төсөл амжилттай хэрэгжиж чадах; эсхүл (ii) Зээлдэгч эсхүл Төслийн гүйцэтгэгч агентлаг нь энэхүү Зээлийн хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлж чадах боломжгүй гэж үзсэн нөхцөл байдал үүсэх буюу бий болсон.

(f) Өөрийн улсын нутаг дэвсгэрт Төслийг хэрэгжүүлэх гишүүн орон нь АХБ-ны гишүүнчлэлээс түдгэлзсэн эсвэл гишүүнчлэлээс хасагдсан эсхүл АХБ-наас гарах мэдэгдэл хүргүүлсэн.

(g) Зээлдэгч нь энэхүү Зээлийн хэлэлцээрт эсхүл түүний хүрээнд гаргасан өөрийн талаарх мэдээлэл, эсвэл АХБ энэхүү Зээлийг олгохдоо найдсан Зээлдэгчийн гаргасан бусад мэдэгдэл нь материаллаг хэмжээнд үнэн бодитой бус.

(h) Хууль ёсны эрх бүхий этгээд нь Төслийн гүйцэтгэгч байгууллагыг халах буюу татан буулгах эсхүл Энгийн үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болгох буюу түдгэлзүүлэхэд хүргэхүйц хэмжээнд түүний хөрөнгийг тусгаарлан авах эсхүл бусдад шилжүүлэх арга хэмжээ авсан.

(i) Зээлдэгч нь зээл төлөх хугацаанд өр төлбөрөө барагдуулах боломжгүй болсон эсхүл Зээлдэгчийн аливаа хөрөнгийг зээлдүүлэгч нарт хуваан олгоход хүргэх алхам буюу ажиллагааг Зээлдэгч эсвэл бусад этгээд авч хэрэгжүүлсэн.

(j) Өөрийн улсын газар нутагт Төслийг хэрэгжүүлэх гишүүн орон эсхүл хууль ёсны эрх бүхий бусад этгээд нь Зээлдэгчийг халах буюу татан буулгах Энгийн үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болгох буюу түдгэлзүүлэхэд хүргэхүйц хэмжээнд түүний хөрөнгийг тусгаарлан авах эсхүл бусдад шилжүүлэх арга хэмжээ авсан.

(k) Аливаа хууль ёсны эрх бүхий этгээд нь Зээлдэгчийг халах буюу татан буулгах Энгийн үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болгох буюу түдгэлзүүлэхэд хүргэхүйц хэмжээнд түүний хөрөнгийг тусгаарлан авах эсхүл бусдад шилжүүлэх арга хэмжээ авсан.

(l) АХБ нь Зээлийн хөрөнгөөс бүхэлдээ болон хэсэгчлэн санхүүжигдэх аливаа гэрээтэй холбогдуулан Зээлдэгчийг төлөөлөгчид эсхүл Зээлийн аливаа үр шим хүртэгчид авилга, залилан, хүч хэрэглэх



болон хуйвалдаан бүхий аливаа ажиллагааг бүтээгдэхүүн, үйлчилгээ болон зөвлөх шалгаруулах, худалдан авах эсхүл гэрээг гүйцэтгэх явцад оролцсон байхад Зээлдэгч нөхцөл байдлыг залруулах үүднээс АХБ-ны шаардлагад нийцэх зохих ёсны арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй гэж үзсэн; эсхүл АХБ нь энэхүү Зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэх аливаа бараа эсхүл үйлчилгээг худалдан авах ажиллагаа нь энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгагдсан холбогдох процедурын дагуу явагдаагүй гэж үзсэн.

(m) Энэ заалттай хамааралтай гэж энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгасан аливаа бусад тохиолдол үүссэн.

Уг эрхийг түдгэлзүүлэх болсон нөхцөл байдал арилсан гэж АХБ-наас зохих ёсоор дүгнэх эсхүл АХБ-наас Зээлдэгчид зарлага хийх эрх нь бүхэлдээ болон хэсэгчлэн сэргээгдсэн болохыг мэдэгдэхийн аль нэг түрүүлж тохиох хүртэл Зээлийн данснаас зарлага хийх эрх түдгэлзсэн хэвээр байна.

Заалт 7.02. АХБ-ны талаас цуцлах. Хэрэв (a) Зээлийн аливаа хөрөнгийг Зээлийн данснаас зарлагадах Зээлдэгчийн эрхийг 30 хоног дараалан түдгэлзсэн хэвээр байвал; (b) АХБ нь Зээлдэгчтэй зөвшилцсөний дараагаар Төслийн зорилгоор Зээлийн ямар нэг хөрөнгийг ашиглах шаардлагагүй гэж үзсэн; (c) энэхүү Зээлийн хэлэлцээрт заасан Зээл хаах өдөр болоход Зээлийн дансанд зарлагадаагүй Зээлийн хөрөнгө үлдсэн; (d) АХБ нь Зээлийн хөрөнгөөс бүхэлдээ болон хэсэгчлэн санхүүжигдэх аливаа гэрээтэй холбогдуулан Зээлдэгчийг төлөөлөгчид эсхүл Зээлийн аливаа үр шим хүртэгчид авилга, залилан, хүч хэрэглэх болон хуйвалдаан бүхий аливаа ажиллагааг бүтээгдэхүүн, үйлчилгээ болон зөвлөх шалгаруулах, худалдан авах эсхүл гэрээг гүйцэтгэх явцад оролцсон байхад Зээлдэгч нөхцөл байдлыг залруулах үүднээс АХБ-ны шаардлагад нийцэх зохих ёсны арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй гэж үзсэн; эсхүл (e) АХБ нь энэхүү Зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэх аливаа бараа эсхүл үйлчилгээг худалдан авах ажиллагаа нь энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгагдсан холбогдох процедурын дагуу явагдаагүй гэж үзсэн бол АХБ нь холбогдох зээлийн дүнд Зээлдэгч зарлага хийх эрхийг цуцалж буйг Зээлдэгчид мэдэгдэж болно. Ийнхүү мэдэгдэл хүргэсний дараа холбогдох дүнд Зээлийг цуцална.

Заалт 7.03. Зээлдэгч талаас цуцлах. Зээлдэгч нь АХБ-тай зөвшилцсөний дараа АХБ-нд тийнхүү мэдэгдэл хүргүүлэхээс өмнө зарлагадаагүй байсан дүнд Зээлийг цуцлах мэдэгдлийг АХБ-нд хүргүүлж болно.

Заалт 7.04. Баталгааны бичигт хамааралтай дүн. Баталгааны бичигт өөрөөр тусгайлан заагаагүй тохиолдолд 4.02 заалтын дагуу АХБ-наас баталгааны бичиг үйлдсэн аливаа дүнд зээл түдгэлзүүлэх

эсхүл цуцлахгүй.

Заалт 7.05. **Зээл цуцлах үйлчлэл.** АХБ болон Зээлдэгч өөрөөр харилцан тохиролцоогүй тохиолдолд цуцлах өдрийн дараа хугацаа дуусах Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэлд зээл дуусах хугацаанд хувьчлан тооцогдох байдлаар аливаа зээл цуцлах үйлчилнэ.

Заалт 7.06. **Зээл түдгэлзүүлсэн эсхүл цуцалсны дараах гэрээний үйлчлэл.** Зээл цуцалсан эсхүл түдгэлзүүлсэн эсэхээс үл хамааран энэхүү Зээлийн хэлэлцээр нь энэ зүйлд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

Заалт 7.07. **Зээлийн хугацааг түргэсгэх.** Дараах тохиолдлын аль нэг үүсэж, тодорхой хугацаанд үргэлжилвэл АХБ-наас тухайн үед төлөгдөөгүй байгаа Зээлийн үндсэн төлбөр болон хуримтлагдсан үйлчилгээний төлбөрийг нэн даруй төлж барагдуулах шаардлагатай болсныг мэдэгдэх ба тухайн мэдэгдэл гаргамагц түүнд заасан үндсэн төлбөр болон үйлчилгээний төлбөрийг нэн даруй төлж барагдуулна:

а) 7.01(a) заалтад тусгасан аливаа тохиолдол үүссэн бөгөөд 30 хоног дараалан үргэлжилсэн.

б) 7.01(b) заалт болон 7.01(c) заалтад тусгасан аливаа тохиолдол үүссэн бөгөөд АХБ-наас Зээлдэгчид мэдэгдэл хүргүүлснээс хойш 60 хоног дараалан үргэлжилсэн.

с) 7.01(g) заалт, 7.01(h) заалт, 7.01(i) заалт болон 7.01(j) заалтад тусгасан аливаа тохиолдол үүссэн.

д) Энэхүү заалтын зорилгоор энэ Зээлийн хэлэлцээрт тусгасан бусад тохиолдол үүссэн бөгөөд хэрэв энэхүү Зээлийн хэлэлцээрт хэрэв хугацаа заасан бол тэр хугацаанд үргэлжилсэн.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

Хүчин төгөлдөр болох; Гэрээ цуцлах

Заалт 8.01. **Хүчин төгөлдөр болоход тавигдах урьдчилсан нөхцөлүүд.** Дараахыг нотолсон баримт бичгийг АХБ-ийн шаардлагад нийцэхүйц байдлаар хүргүүлсэн нөхцөлд энэхүү Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр хэрэгжинэ. Үүнд:

а) Зээлдэгчийн нэрийн өмнөөс энэхүү Зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурж, хүргүүлснийг байгууллагын болон Засгийн газрын шаардлагатай бүх үйлдлээр эрх олгосон буюу хүлээн зөвшөөрч баталгаажуулсан;



b) Төслийн гүйцэтгэгч байгууллагын нэрийн өмнөөс Төслийн гэрээнд гарын үсэг зурж, хүргүүлснийг байгууллагын болон засгийн газрын шаардлагатай бүх үйлдлээр эрх олгосон буюу хүлээн зөвшөөрч баталгаажуулсан;

с) энэхүү Зээлийн хэлэлцээрийг байгуулах өдрийн байдлаар АХБ-нд мэдэгдсэн Зээлдэгчийн нөхцөл байдалд тухайн Зээлийн хэлэлцээрийг байгуулсан өдрөөс эхлэн энэхүү Заалттай холбогдуулж Зээлдэгч болон АХБ нарын хувьд харилцан тохиролцсон өдөр хүртэл хугацаанд ноцтой сөрөг өөрчлөлт болоогүй бөгөөд энэхүү нөхцөл нь АХБ холбогдох ноцлох баримт бичгийг хүргүүлэхийг хүссэн тохиолдолд үйлчилнэ; болон

d) энэхүү Зээлийн хэлэлцээрийг хүчин төгөлдөр болоход шаардлагатай нэмэлт нөхцөлүүд болох энэхүү Зээлийн хэлэлцээрт заасан бусад бүх үйл явдал хэрэгжсэн.

Заалт 8.02. Хууль зүйн дүгнэлт. Дээрх 8.01-р заалтын дагуу хүргүүлэх нотолгоо баримт бичгийн нэг хэсэг болгож Зээлдэгч дараахыг агуулсан хууль зүйн дүгнэлтийг АХБ-ны шаардлагад нийцэхүйц буюу хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр АХБ-нд хүргүүлэх буюу хүргүүлэх явдлыг хангана. Үүнд:

(a) Энэхүү Зээлийн хэлэлцээрийг Зээлдэгч зохих ёсоор эрх олгосон буюу баталсан, Зээлдэгчийн нэрийн өмнөөс гарын үсэг зурж хүргүүлсэн бөгөөд энэхүү Зээлийн хэлэлцээр нь Зээлдэгчийн хувьд энд заасан нөхцөл болзлуудын дагуу хууль зүйн хувьд заавал биелэгдэх хүчинтэй болох талаар Зээлдэгчийн нэрийн өмнөөс;

(b) Төслийн гэрээг Төслийн гүйцэтгэгч байгууллага зохих ёсоор эрх олгосон буюу баталсан, Төслийн гүйцэтгэгч байгууллагын нэрийн өмнөөс гарын үсэг зурж хүргүүлсэн бөгөөд Төслийн гэрээ нь Төслийн гүйцэтгэгч байгууллагын хувьд тэнд заасан нөхцөл болзлуудын дагуу хууль зүйн хувьд заавал биелэгдэх хүчинтэй болох талаар Төслийн гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс; болон

(c) энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгасан бусад асуудлууд.

Заалт 8.03. Хүчин төгөлдөр болох өдөр. (a) Хэрэв Зээлдэгч болон АХБ нар өөрөөр харилцан тохиролцоогүй бол 8.01-р заалтад заасан нотлох баримт бичгүүдийг хүлээн зөвшөөрсөн болох мэдэгдлийг АХБ-наас Зээлдэгчид хүргүүлсэн өдрөөс эхлэн энэхүү Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр хэрэгжинэ.

(b) Хэрэв энэхүү Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр хэрэгжиж байсан бол Зээлдэгчийг Зээлийн данснаас мөнгөн хөрөнгө авах эрхийг түдгэлзүүлэх эрхийг АХБ-нд олгоход хүргэх нөхцөл байдалтай адил нөхцөл байдал Хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө үүссэн тохиолдолд АХБ нь энэхүү заалтын (a) хэсэгт заасан мэдэгдлийг тухайн үйл явдал үйлчлэхээ болих хүртэл хугацаанд хүргүүлэлгүй хойшлуулах эрхтэй.

Заалт 8.04. Хүчин төгөлдөр болоогүйн улмаас гэрээг цуцлах. Хэрэв энэхүү заалттай холбогдуулж энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгасан өдөр буюу түүнээс өмнө энэхүү Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болоогүй бол энэхүү Зээлийн хэлэлцээр болон үүний дагуу талуудын хүлээх бүх үүрэг цуцлагдана. Гэхдээ ийнхүү хойшилсон шалтгааныг харгалзан үзсэний үндсэн дээр АХБ энэхүү заалттай холбогдуулж шинээр өөр өдөр товлосон тохиолдолд энэхүү Зээлийн хэлэлцээр цуцлагдахгүй. АХБ нь шинээр тогтоосон өдрийн талаар Зээлдэгчид цаг алдалгүй мэдэгдэнэ.

Заалт 8.05. Төлбөрийг бүрэн төлсөн нөхцөлд гэрээг цуцлагдах. Хэрэв Зээлийн данснаас авсан Зээлийн үндсэн бүх төлбөр, энэхүү Зээлтэй холбогдох үйлчилгээний бүх шимтгэлийг болон Зээлтэй холбогдох бусад хураамжийг (үүнд Менежментийн төлбөр орно) эргүүлэн төлсөн бол энэхүү Зээлийн хэлэлцээр болон үүний дагуу талуудын хүлээх бүх үүрэг нэн даруй цуцлагдана.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Хүчин төгөлдөр хэрэгжих; Эрхээ хэрэгжүүлэхгүй байх; Арбитр

Заалт 9.01. Хүчин төгөлдөр хэрэгжих. (a) Энэхүү Зээлийн хэлэлцээрийн дагуу олгосон АХБ болон Зээлдэгчийн эрх, үүргүүд нь хүчин төгөлдөр бөгөөд холбогдох нөхцөл болзлуудын дагуу хүчин төгөлдөр хэрэгжүүлэх боломжтой эрх, үүргүүд байна. Зээлдэгч нь гишүүн улс бол тухайн улсын аливаа муж, улс төрийн эсвэл засаг захиргааны нэгжийн хуулиас үл хамааран энэхүү Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр хэрэгжинэ.

(b) Азийн Хөгжлийн Банкний үүсэн байгуулсан гэрээний аливаа заалттай холбогдуулж эсвэл аливаа бусад шалтгааны улмаас энэхүү Зээлийн хэлэлцээрийн аливаа заалт хүчин төгөлдөр бус эсвэл хүчин төгөлдөр хэрэгжих боломжгүй гэсэн аливаа шаардлагыг АХБ болон Зээлдэгчийн аль аль нь гаргахгүй.

Заалт 9.02. Эрхээ хэрэгжүүлэхгүй байх. Гэрээг зөрчсөний улмаас энэхүү Зээлийн хэлэлцээрийн дагуу аль нэг талын эдлэх эрх, бүрэн эрх эсвэл эрх хамгаалах арга хэмжээг аваагүй хойшуулсан нь тухайн эрх,



бүрэн эрх эсвэл эрх хамгаалах хэрэгсэлд сөргөөр нөлөөлөхгүй, эдгээрээс татгалзсан эсвэл холбогдох гэрээний зөрчлийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэхгүй. Тухайн холбогдох талын аливаа гэрээний зөрчилтэй холбогдуулж авсан арга хэмжээ эсвэл гэрээний зөрчлийг хүлээн зөвшөөрсөн нь аливаа бусад эсвэл түүний дараах гэрээний зөрчилтэй холбогдуулж тухайн талын эдлэх эрх, бүрэн эрх эсвэл эрх хэрэгжүүлэх арга хэмжээнд нөлөөлөхгүй буюу сөргөөр нөлөөлөхгүй.

Заалт 9.03. Арбитр. (а) Энэхүү Зээлийн хэлэлцээрийн талуудын хооронд үүссэн аливаа зөрчил болон энэхүү Зээлийн хэлэлцээрийн дагуу нэг талаас нөгөө талын эсрэг гаргах аливаа шаардах эрхийг хэрэв талууд эвлэрлийн журмаар шийдвэрлээгүй бол

(b) Энэхүү арбитрын талууд нь АХБ банк нэг тал, Зээлдэгч нөгөө тал байна.

(c) Арбитрын шүүх бүрэлдэхүүнд дараах арбитрын шүүгч нарыг томилно: АХБ нь нэг арбитрын шүүгчийг томилно; хоёрдогч шүүгчийг Зээлдэгч томилно; мөн гуравдагч шүүгч (“Ерөнхий шүүгч гэх”)-ийг хоёр тал зөвшилцөн томилно эсвэл хоёр тал харилцан зөвшилцөж чадахгүй тохиолдолд Олон улсын шүүхийн тэргүүн, эсхүл тэрээр томилж чадахгүй тохиолдолд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга томилно. Хэрэв хоёр тал арбитрын шүүгч томилж чадахгүй байх тохиолдолд Ерөнхий шүүгч нь тэрхүү арбитрын шүүгчийг томилно. Энэхүү заалтын дагуу томилогдсон шүүгч огцрох, нас барах эсхүл албан үүргээ биелүүлэх боломжгүй болох тохиолдолд түүнийг залгамжлах арбитрын шүүгчийг дээр дурдсан анхны шүүгч нарыг томилоход ашигласан аргаар томилох ба шинээр томилогдох шүүгч нь анхны арбитрын эрх мэдэл, албан үүргийг бүхэлд нь залгамжлан авна.

(d) Энэхүү заалтад тусгасан арбитрын ажиллагааг нэг тал нь нөгөө талд эсвэл талуудад уг ажиллагааг эхлүүлэх болсон талаарх мэдэгдэл хүргүүлснээр эхлүүлж болно. Уг мэдэгдэлд арбитрын шүүхэд ямар маргаан эсвэл нэхэмжлэл гаргаж буй, гомдлоо хэрхэн барагдуулах хүсэлтэй байгаа талаарх агуулга, тухайн ажиллагааг эхлүүлж буй талын томилсон арбитрын шүүгчийн нэрийг тусгасан байна. Энэхүү мэдэгдлийг хүргүүлснээс хойш 30 хоногийн дотор нөгөө тал эсвэл талууд гомдол гаргасан талд өөрийн томилж буй арбитрын шүүгчийн нэрийг мэдэгдэнэ.

(e) Арбитрын шүүхэд гомдол гаргаж буй талаарх мэдэгдэл хүргүүлснээс хойш 60 хоногийн дотор Ерөнхий шүүгчээ томилох асуудлаар зөвшилцөлд хүрч чадахгүй бол талуудын аль нэг нь энэхүү заалтын (c) хэсэгт тусгасанчлан Ерөнхий шүүгчийг томилох хүсэлт гаргаж болно.

(f) Арбитрын хурал нь Ерөнхий шүүгчийн тогтоосон өдөр, газарт болно. Түүний дараа Арбитрын шүүх бүрэлдэхүүн хаана, хэзээ дахин хуралдахыг шийдвэрлэнэ.

(g) Арбитрын хуралд ашиглах хууль нь олон улсын нийтийн эрх зүй байх ба үүний хүрээнд дараах эх сурвалжуудыг ашиглана:

(i) бүх талуудад харилцан хууль ёсоор үйлчлэх холбогдох гэрээний үүргүүд;

(ii) тусгаар улс болон олон улсын байгууллагуудад хамааралтай уламжлалт хуулийг хууль ёсны дүрэм болгож боловсруулсан эсвэл хэвшүүлсэн гэж нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын гэрээ, конвенц (талуудад шууд хууль ёсоор үйлчлэх эсэхээс үл хамаарна);

(iii) бусад төрлийн олон улсын заншсан уламжлал, үүнд хуулийн үүрэг үүсгэх талаарх нийтлэг байдал, нийцэлтэй байдал болон бат бөх байдал улс орнууд болон олон улсын байгууллагуудын практик орно; мөн

(iv) холбогдох эрх зүйн ерөнхий зарчмууд.

(h) Энэхүү заалтад тусгасанчлан мөн талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол Арбитрын шүүх бүрэлдэхүүн өөрийн чадавх болон процедуртай холбоотой бүхий асуудлуудыг өөрсдөө шийдвэрлэнэ. Арбитрын шүүхээс гарах бүх шийдвэрийг дийлэнхийн саналаар шийдвэрлэнэ.

(i) Арбитрын шүүх нь бүх талуудад шударга шүүгдэх боломжоор хангах ба шүүхийн шийдвэрийг бичгээр гаргана. Тухайн шийдвэрийг дифолтоор гаргаж болно. Арбитрын шүүх бүрэлдэхүүний дийлэнхийн гарын үсэг зурсан шийдвэр нь тухайн шүүх хурлын шийдвэр мөн. Шийдвэрийн нэмэлт хувь дээр гарын үсэг зурж бүх талуудад хүргүүлнэ. Энэхүү заалтын дагуу гаргасан шүүхийн шийдвэр нь эцсийн байх ба Зээлийн хэлэлцээрийн бүх талуудад хууль ёсоор үйлчилнэ. Энэхүү заалтад заасанчлан гаргасан Арбитрын шүүхийн шийдвэрийг бүх тал хүндэтгэн дагаж мөрдөнө.

(j) Талууд нь арбитрын шүүх ажиллагааг явуулахад шаардлагатай арбитрын шүүгч нар болон бусад хүмүүст төлөх хөлсийг хамтран тогтооно. Хэрэв талууд арбитрын хурлаас өмнө хөлсний үнийн дүн дээр тохиролцож чадахгүй байх тохиолдолд арбитрын шүүхээс тухайн нөхцөлд шударга гэж үзсэн дүнг тогтооно. Талууд өөрсдийн арбитрын шүүхэд өмгөөлүүлэхтэй холбоотой зардлыг өөрсдөө гаргана. Арбитрын шүүх ажиллагаатай холбоотой зардлыг нэг талаас АХБ, нөгөө талаас Зээлдэгч хувааж төлнө. Арбитрын шүүх хурлын зардлыг хуваах эсхүл тухайн зардлыг төлөх процедуртай холбоотой асуудлыг Арбитрын шүүх шийднэ.



(к) Энэхүү Зээлийн хэлэлцээрийн талуудын аль нэг нь нөгөө талд гомдол гаргаж, маргааныг бусад аргаар шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд энэхүү заалтад тусгасан арбитрай холбоотой заалтыг хэрэглэнэ.

(л) Хэрэв арбитрын шүүхийн шийдвэрийг талуудад хүргүүлсний дараа 30 хоногийн дотор шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх тохиолдолд аль нэг тал нь тухайн нөгөө талын харьяалал бүхий шүүхэд хандан уг шийдвэрийг гүйцэтгүүлэхээр арга хэмжээ авах эсхүл гүйцэтгүүлэх шийдвэр шүүхээр гаргуулах, эсвэл тухайн шийдвэр болон энэхүү Зээлийн хэлэлцээрийг хуулиар гүйцэтгүүлэх бусад аргыг хэрэглэж болно. Дээр дурдсанаас үл хамааран ийм процедурыг хэрэглэх боломжтой байхаас бусад тохиолдолд энэхүү заалт нь гишүүн орон болох аливаа талын эсрэг шийдвэрийг шууд хэрэгжүүлэх эсхүл гүйцэтгүүлэх эрхийг олгоогүй болно.

(м) Аливаа мэдэгдлийн үйлчилгээ эсхүл энэхүү заалтын хүрээнд явуулах ажиллагаатай холбоотой явагдсан процесс эсхүл (ийнхүү шийдвэрлэх боломж байгаагийн хэрээр) энэхүү заалтын хүрээнд шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх аливаа ажиллагаатай холбоотойгоор явагдсан процесс нь энэхүү 9.01 заалтын дагуу явагдана. Энэхүү Зээлийн хэлэлцээрийн талууд нь энэхүү үйлчилгээний шаардлагуудын аль нэгийг эсхүл бүхэлд нь чөлөөлж болно.

АРАВДУГААР ЗҮЙЛ

Бусад заалтууд

Заалт 10.01. Мэдэгдэл ба хүсэлтүүд. Энэхүү Зээлийн хэлэлцээрийн хүрээнд өгөх шаардлагатай эсхүл зөвшөөрөгдсөн мэдэгдэл эсхүл хүсэлт; мөн энэхүү Зээлийн хэлэлцээрт байгуулсан аливаа талуудын тохиролцоог бичгээр үйлдэнэ. 8.03 заалтад өөрөөр заагаагүй бол тэрхүү мэдэгдэл эсхүл хүсэлт нь биечлэн эсхүл шуудан, цахим шуудангаар дамжуулан хүлээн авах талын энэхүү Зээлийн хэлэлцээрт тэрхүү мэдэгдэл эсхүл хүсэлтийг хүлээн авах хаяг гэж заасан хаягт хүргүүлснээр хүлээлгэн өгсөн эсхүл хүргүүлсэнд тооцно.

Заалт 10.02. Төлөөлөх эрх мэдэл. Энэхүү Зээлийн хэлэлцээрт Зээлдэгчийг төлөөлж шаардлагатай эсхүл зөвшөөрөгдсөн үйлдэл хийх мөн шаардлагатай эсхүл зөвшөөрөгдсөн баримт бичгийг үйлдэх эрхтэй этгээд нь Зээлдэгчийн энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгасан төлөөлөгч эсхүл түүний бичгээр мэдэгдэж томилсон хүн байна. Зээлдэгчийн томилсон түүнийг төлөөлөх эрх бүхий төлөөлөгч эсхүл түүний бичгээр баримт үйлдэж төлөөлөх эрх авсан өөр нэг этгээд нь Зээлдэгчийг төлөөлж

бичгээр үйлдсэн хэрэгслээр дамжуулан энэхүү зээлийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэхдээ энэ нь тухайн төлөөлөгч эсхүл түүний томилсон этгээдийн үзэж буйгаар уг өөрчлөлт нь тухайн нөхцөлд зохих ёсны бөгөөд Зээлдэгчийн энэхүү Зээлийн хэлэлцээрт хүлээсэн үүргийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэхгүй өөрчлөлт гэж үзэж буй тохиолдолд хамаарна. АХБ нь тухайн төлөөлөгч болон түүний томилсон этгээдийн үйлдсэн энэхүү хэрэгслийг тухайн төлөөлөгч эсхүл түүний төлөөлөгч энэхүү Зээлийн хэлэлцээрт орсон тухайн нэмэлт, өөрчлөлт нь уг нөхцөл байдалд зохистой бөгөөд Зээлдэгчийн үүргийг үлэмж хэмжээнд нэмэгдүүлэхгүй гэж үзсэн хөдөлшгүй нотолгоо гэж хүлээн зөвшөөрч болно.

Заалт 10.03. Төлөөлөх эрх мэдлийн нотолгоо. Зээлдэгч нь АХБ-инд Зээлдэгчийг нэрийн өмнөөс энэхүү Зээлийн хэлэлцээрт Зээлдэгч талын үйлдэх эсхүл зөвшөөрөх болон хүлээн авах баримт бичгийг үйлдэх, зөвшөөрөх болон хүлээн авах эрх бүхий этгээдийн төлөөлөх эрхийг батлах хангалттай нотолгоог, тухайн албан тушаалтан бүрийн баталгаат гарын үсгийн хамт ирүүлнэ.

Заалт 10.04. Гишүүний хувьцааны төлбөрийг суутган үлдээх

(а) Өөрийн орны газар нутагт Төслийг хэрэгжүүлэх улс нь АХБ-ны гишүүн байхаа болих тохиолдолд АХБ-наас хувьцааг буцаан худалдан авсантай холбогдуулан төлөх төлбөрийг тухайн гишүүн, түүний төв банк эсхүл агентлагууд, эсвэл орон нутгийн засаг захиргаа нь энэхүү Зээлийн хэлэлцээр эсхүл АХБ-тай байгуулсан өөр бусад зээлийн гэрээ эсхүл барьцааны гэрээний хүрээнд өр төлбөр барагдуулах хүртэл өөрт хадгалахын сацуу тус банкны шийдвэрээр тухайн өр төлбөрийн хугацаа болмогц суутгах болно.

(b) АХБ-ны хөрөнгийг хуваах нөхцөл байдал үүсвэл Төслийг өөрийн газар нутагт хэрэгжүүлж буй улс нь энэхүү Зээлийн хэлэлцээр эсхүл АХБ-тай байгуулсан бусад зээлийн гэрээ эсхүл баталгааны гэрээний хүрээнд үүссэн төлбөрийн үүргээ биелүүлэх хүртэл тус улсад олгох хөрөнгийн хувийг олгохгүй.

Заалт 10.05. Талуудад тараах хэлэлцээрийн хувь. Энэхүү Зээлийн хэлэлцээрийг талуудын тоогоор хувь үйлдэх ба тэдгээр нэг бүр эх хувь байна.



ХУВААРЬ 2

Зээлийг эргэн төлөх хуваарь

Төлбөр төлөх өдөр төлбөр	Үндсэн зээлийн (ам.доллар)
2029 оны 2-р сарын 15	950,000
2029 оны 8-р сарын 15	950,000
2030 оны 2-р сарын 15	950,000
2030 оны 8-р сарын 15	950,000
2031 оны 2-р сарын 15	950,000
2031 оны 8-р сарын 15	950,000
2032 оны 2-р сарын 15	950,000
2032 оны 8-р сарын 15	950,000
2033 оны 2-р сарын 15	950,000
2033 оны 8-р сарын 15	950,000
2034 оны 2-р сарын 15	950,000
2034 оны 8-р сарын 15	950,000
2035 оны 2-р сарын 15	950,000
2035 оны 8-р сарын 15	950,000
2036 оны 2-р сарын 15	950,000
2036 оны 8-р сарын 15	950,000
2037 оны 2-р сарын 15	950,000
2037 оны 8-р сарын 15	950,000
2038 оны 2-р сарын 15	950,000
2038 оны 8-р сарын 15	950,000
2039 оны 2-р сарын 15	1,900,000
2039 оны 8-р сарын 15	1,900,000
2040 оны 2-р сарын 15	1,900,000
2040 оны 8-р сарын 15	1,900,000
2041 оны 2-р сарын 15	1,900,000
2041 оны 8-р сарын 15	1,900,000
2042 оны 2-р сарын 15	1,900,000
2042 оны 8-р сарын 15	1,900,000
2043 оны 2-р сарын 15	1,900,000
2043 оны 8-р сарын 15	1,900,000
2044 оны 2-р сарын 15	1,900,000
2044 оны 8-р сарын 15	1,900,000
2045 оны 2-р сарын 15	1,900,000

2045 оны 8-р сарын 15	1,900,000
2046 оны 2-р сарын 15	1,900,000
2046 оны 8-р сарын 15	1,900,000
2047 оны 2-р сарын 15	1,900,000
2047 оны 8-р сарын 15	1,900,000
2048 оны 2-р сарын 15	1,900,000
2048 оны 8-р сарын 15	1,900,000
2049 оны 2-р сарын 15	1,900,000
2049 оны 8-р сарын 15	1,900,000
2050 оны 2-р сарын 15	1,900,000
2050 оны 8-р сарын 15	1,900,000
2051 оны 2-р сарын 15	1,900,000
2051 оны 8-р сарын 15	1,900,000
2052 оны 2-р сарын 15	1,900,000
2052 оны 8-р сарын 15	1,900,000
2053 оны 2-р сарын 15	1,900,000
2053 оны 8-р сарын 15	1,900,000
2054 оны 2-р сарын 15	1,900,000
2054 оны 8-р сарын 15	1,900,000
2055 оны 2-р сарын 15	1,900,000
2055 оны 8-р сарын 15	1,900,000
2056 оны 2-р сарын 15	1,900,000
2056 оны 8-р сарын 15	1,900,000
2057 оны 2-р сарын 15	1,900,000
2057 оны 8-р сарын 15	1,900,000
2058 оны 2-р сарын 15	1,900,000
2058 оны 8-р сарын 15	1,900,000

Нийт 95,000,000

- Эргэн төлөлт хийх зохицуулалт нь Стандарт нөхцөлийн заалт 2.06 болон 3.05-аас хамааран үйлчилнэ.



ХУВААРЬ 3

Зээлийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт

Ерөнхий зүйл

1. Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлын ангилал болон зээлээс тэдгээр ангилал тус бүрд хуваарилсан санхүүжилтийн хэмжээг энэхүү Хуваарьт хавсаргасан хүснэгтэд харуулсан болно (“Хүснэгт” гэх).

Зээлийн данснаас гүйлгээ хийх нөхцөл

2. АХБ-тай өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд ангилал бүрийн зардлыг Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхдээ Хүснэгт дэх хувь хэмжээг баримтална.

Үйлчилгээний шимтгэл ба Үүрэг хүлээсний төлбөр

3. “Хүүгийн шимтгэл” гэх ангилалд хуваарилсан хөрөнгө нь Төсөл хэрэгжүүлэх хугацаанд төлөх Зээлийн үйлчилгээний шимтгэл ба хөрөнгө баталгаажуулсны төлбөрийг санхүүжүүлэхэд зориулагдсан болно. АХБ нь Зээлийн данснаас зарлага хийж, Зээлдэгчийн нэрийн өмнөөс тэдгээр үйлчилгээний болон Үүрэг хүлээсэн төлбөрийг төлөх хугацаа болмогц шаардлагатай дүнгээр зарлагадан өөрөө өөртөө төлнө.

Дахин хуваарилалт

4. Зээлийн хөрөнгийн хуваарилалт, хүснэгтэд заасан санхүүжилтийн хувь хэмжээг үл харгалзан,

(а) Хэрэв аль нэг ангилалд хуваарилсан Зээлийн хэмжээ нь тухайн ангиллын хүрээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй бол АХБ Зээлдэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр: (i) өөр ангилалд хуваарилагдсан боловч бусад зардлыг санхүүжүүлэхэд ашиглагдахгүй гэж АХБ үзсэн хөрөнгөөс тухайн ангилалд дутагдаж байгаа санхүүжилтийг нөхөх хэмжээгээр дахин хуваарилна, (ii) хэрэв дахин хуваарилсан хөрөнгө нь хүрэлцэхгүй бол тухайн ангиллын хүрээнд хийгдэх бусад зарцуулалтыг үргэлжлүүлэх үүднээс хөрөнгө дутагдсан зардалд анх зарцуулахаар төсөвлөсөн хөрөнгийн хувь хэмжээг багасгана; мөн

(b) Хэрэв нэг ангилалд хуваарилсан хөрөнгө нь уг ангилалд шаардагдах зардлын хэмжээнээс илүү гарвал АХБ Зээлдэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр энэхүү илүү гарсан санхүүжилтийг өөр ангилалд дахин хуваарилна.

Зарцуулалт хийх журам

5. АХБ өөрөөр тохирсноос бусад тохиолдолд Зээлийн хөрөнгийг “Зээлийн зарцуулалтын гарын авлага” болон АХБ, Зээлдэгч хооронд харилцан тохиролцсон нарийн зохицуулалтын дагуу зарцуулалт хийгдэнэ.

Хуваарь 3

Нөхөн санхүүжилт

6. УАНС-гаас бичгээр урьдчилан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд Хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө Зээлийн хөрөнгөөс аливаа зардал, амлалтыг санхүүжүүлэхэд ашиглахгүй.

Зээлийн данснаас зарцуулалт хийх нөхцөл

7. Энэхүү Зээлийн хэлэлцээрт тусгасан бусад заалтаас үл хамааран Энгийн үйл ажиллагааны [хөнгөлөлттэй] зээлийн хэлэлцээрийн Хуваарь 3-ын 6-р дэд хэсэгт тусгасан нөхцөлүүдийг хангахаас нааш Ангилал 1 ба 4-ийн хүрээнд Зээлийн данснаас аливаа хөрөнгө зарлагдахгүй болно.

Хуваарь 3-ын хавсралт

ХҮСНЭГТ

Зээлийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт				
Дугаар	Зориулалт	УАНС-гаас санхүүжүүлэх нийт хэмжээ (\$)		Зээлийн данснаас гарах хувь
		Ангилал	Дэд ангилал	
	Бүрэлдэхүүн хэсэг 1			
1	Ажил (нарны хавтан)+	15,580,000		Нийт нэхэмжилсэн зардлын 61%



2	Үйлчилгээний төлбөр болон хөрөнгө баталгаажуулсны төлбөр	850,000		Нийт төлбөрийн 100%
3	Магадлашгүй зардал	2,870,000		
	дэд нийлбэр (Бүрэлдэхүүн хэсэг 1)	19,300,000		
	Бүрэлдэхүүн хэсэг 2			
4	Санхүүгийн зуучлалын зээлийн бүрэлдэхүүн хэсэг+	75,700,000		Нийт нэхэмжилсэн зардлын 100%*
	НИЙТ	95,000,000		

* Зээлдэгчийн нутаг дэвсгэрт ногдуулах дотоодын татвар, хураамжийг оруулаагүй.

+ Хавсралт 3-ын 7-р дэд хэсэгт дурдсан зарцуулалт хийх нөхцөл үйлчилнэ.

ХУВААРЬ 4

Төслийн гүйцэтгэл

1.Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч агентлагуудаар дамжуулан УАНС-гийн зээлийн хөнгөлөлтийг шаардлага хангасан барилгын компани болон орон сууц худалдан авагч нарт дамжуулан эдлүүлэх; мөн шаардлага хангасан барилгын компани эсхүл орон сууц худалдан авагч нартай дамжуулан зээлдэх гэрээ байгуулахдаа (a) зах зээлийн түвшнөөс илүү хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлэх нөхцөл болон (b) шаардлага хангасан орон сууц худалдан авагчийн хөрөнгө, орлогод нийцсэн ипотекийн зээлийн төлбөрийг тусгана.

2.Зээлдэгч нь энэхүү Зээлийн хэлэлцээртэй холбогдуулан эсхүл түүний хүрээнд АХБ-ны Уур амьсгалын ногоон сан, төсөл эсхүл АХБ-ны үйлдэл, эс үйлдэл эсхүл түүний ажилчид, ажилтан, төлөөлөгч, зөвлөхөөс үүдэх хохиролтой холбогдуулан гэрээ, гэм хор эсхүл хуульд заасан зохицуулалтын хүрээнд байхаас үл хамааран УАНС-гийн эсрэг аливаа хуулийн арга хэмжээ, гомдол гаргах эрхгүй гэдгээ хүлээн зөвшөөрч буй болно.

3.Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллага болон Төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан, УАНС-гаас шаардах аливаа хяналт, гэнэтийн шалгалт, баталгаажуулалт болон үнэлгээ явуулахад АХБ-тай бүрэн хамтран ажиллана.

4.Зээлдэгч нь, Төслийн гүйцэтгэгч байгууллага болон Төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан, хэрэв УАНС-гаас зээлийн хөрөнгийн ашиглалтын талаар асуудал гарсан гэж үзвэл АХБ-наас хөндлөнгийн аудитор авч, төсөлд санхүүгийн аудитын шалгалт хийлгүүлэх АХБ-ны эрхийг хүлээн зөвшөөрч буй бөгөөд тэрхүү аудитын шалгалттай холбоотойгоор хамтран ажиллана. Хэрэв зээлийн хөрөнгийг энэхүү Зээлийн хэлэлцээрт заасанчлан ашиглаагүй болохыг аудитын шалгалтаар тогтоовол Зээлдэгч нь тэрхүү аудитын шалгалтын зардлыг хариуцна.

5.Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллага болон Төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан, төслийг хэрэгжүүлж, гүйцэтгэх мөн төслийн барилга байгууламжийг ашиглахтай холбоотой шаардлагатай бөгөөд холбогдох тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл (үүнд оюуны өмчийнх хамаарна) болон хүлээн зөвшөөрсөн бичгийг төслийн бүхий л шатанд хүчинтэй байлгах үүргийг хүлээнэ.

6.Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллага болон Төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан, төсөлтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг тухайн хууль тогтоомж хамааралтай бол Зээлдэгчийн хууль тогтоомж болон түүний хүлээн зөвшөөрсөн бусад хуулийн дагуу зохих хэмжээнд нийцүүлэн хэрэгжүүлэх нөхцөлөөр хангана.

7.Зээлдэгч нь Төслийн санхүүжүүлэгч УАНС-гийн таниулах тал дээр хүчин чармайлт гарган ажиллана (ө.х. УАНС-гийн логог түүний брэндийн журмын дагуу ашиглах, тайлан, хэвлэмэл материал болон олон



нийтэд тараах сурталчилгааны аливаа материалд зохих хэмжээнд дурдах мөн дэд бүтцийн ажил явагдах газар УАНС-гийн логог хадах). УАНС-гийн брэндийг сурталчлах аливаа үйл ажиллагааг явуулахдаа тус сангийн брэндийн журмыг баримтлахын сацуу УАНС-гийн Ажлын албаар хянуулна.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3

Индекс: 200003